

# ТОВЬЁОГ

*Агуулга*

*хуудасны дугаар*

## **Нэг. ИРГЭДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ХЭСЭГЧИЛСЭН ТАЙЛАН**

1.1.	Судалгааны үзүүлэлтүүд	4-19
1.2.	Судалгааны ерөнхий үнэлгээ ( дүгнэлт )	20-22
1.3.	Зөвлөмж	23
1.4.	Хавсралт	24

## **Хоёр. ХАМТРАН АЖИЛЛАДАГ БАЙГУУЛЛАГЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ХЭСЭГЧИЛСЭН ТАЙЛАН**

2.1.	Судалгааны үзүүлэлтүүд	26-35
2.2.	Судалгааны ерөнхий үнэлгээ( дүгнэлт )	35-39
2.3.	Зөвлөмж	40

## **Гурав. УЛААНБААТАР ХОТЫН ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧДЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

3.1.	Судалгааны үзүүлэлтүүд	42-54
1.5.	Судалгааны ерөнхий үнэлгээ ( дүгнэлт )	55-56
3.2.	Зөвлөмж	57
3.3.	Хавсралт	58-60

**ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААН  
ДАХЬ ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ-2017**

**Нэг. ИРГЭДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН  
СУДАЛГААНЫ ХЭСЭГЧИЛСЭН ТАЙЛАН**

*(Нийслэлийн 6 дүүргийн хэмжээнд)*

# 1. УДИРТГАЛ

## 1.1 Судалгааны үндэслэл, шаардлага

Монгол Улсын Засгийн Газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын шалгуур үзүүлэлт”, Хууль зүйн сайдын 2014 оны А/01 дүгээр тушаалаар батлагдсан “Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт-шинжилгээ үнэлгээний аргачлал”-ийг үндэслэн Цагдаагийн Ерөнхий Газар хэрэглэгчийн үнэлгээний тайланг жил бүр гаргах үүрэг хүлээсэн.

2012-2016 оны хооронд Цагдаагийн Ерөнхий Газрын захиалгаар хөндлөнгийн судалгааны байгууллагууд “Цагдаагийн байгууллагын хэрэглэгчийн үнэлгээний тайлан”-г 5 удаа гаргажээ. Судалгааны дүнгээс үзвэл цагдааг үнэлэх хэрэглэгчийн үнэлгээ жил бүр нэмэгдэж байгаа талаар дурдсан байна.

Иргэд гэмт хэргийн тухай гомдол мэдээллийг цагдаад мэдээлэхгүй байх, улмаар иргэд оршин суугаа нутаг дэвсгэртээ аюулгүй тайван амьдрах итгэлгүй болж, гэмт хэргээс түгших мэдрэмж нэмэгддэг. Иймээс гэмт хэргтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг сайжруулах, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар олон нийтийн итгэлийг хүлээх ажлыг хэрэгжүүлэхэд хэрэглэгчийн үнэлгээний судалгаа онцгой ач холбогдолтой.

## 1.2 Судалгааны ажлын зорилго, зорилт

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг үнэлэх хэрэглэгчийн үнэлгээний аргачлал боловсруулах, боловсруулсан аргачлалын дагуу судалгаа явуулж, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд үнэлгээ өгөх, цаашид авах арга хэмжээний зөвлөмж боловсруулахад оршино.

Судалгааны ажлын хүрээнд цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд өгөх хэрэглэгчийн үнэлгээг тодорхойлж, дүн шинжилгээ хийх зорилт дэвшүүлсэн болно.

## 1.3 Судалгааны ажлын онцлог

Цагдаагийн байгууллагын хэрэглэгчийн үнэлгээг тодорхойлох зорилгоор өмнө нь явуулсан судалгаа нь ихэнх тохиолдолд Улаанбаатар хотын дүүргүүдийн 575-1200 иргэний дунд явуулдаг байсан бол энэ удаа нийслэлийн 6 дүүрэг, 21 аймгийн төлөөллийг бүхэлд нь хамруулсан, өмнө нь хийгдсэн судалгааны арга зүй, санал асуулгын хуудсанд ашигласан асуулт нь харилцан адилгүй, агуулгын хувьд ихээхэн ялгаатай байсан бол энэ байдлыг харгалзан цагдаагийн байгууллагын хэрэглэгчийн үнэлгээний асуулгыг боловсруулахдаа олон улсын хэмжээнд түгээмэл хэрэглэдэг аргачлалд тулгуурлан боловсруулсан, судалгааны үр дүнг Улаанбаатар хотын дүүрэг, тус бүрээр нь гаргаж, дундаж оноогоор нь эрэмбэлэн харуулсан зэрэг болно.

## 1.4 Судалгааны арга зүй, түүвэрлэлт

### *Судалгааны түүвэрлэлт*

Судалгаанд дүүрэг тус бүрээс 30 иргэн буюу 6 дүүргийн 178 иргэд судалгаанд оролцсон. Судалгааны түүвэрлэлтийг хийхдээ нийслэлийн 2017 оны байдлаар цагдаагийн байгууллагаар үйлчлүүлсэн иргэд байх ёстой гэсэн шалгуурыг удирдлага болгосон. Дээрх иргэдийг ЦЕГ-

ын мэдээлэл нэгтгэн боловсруулах төвийн мэдээллийн сангаас санамсаргүй түүврийн аргаар сонгож авсан болно.

*Хүснэгт №1*

д/д	Дүүрэг	Хамрагдсан иргэдийн тоо
1	Баянгол	30
2	Баянзүрх	30
3	Сонгинохайрхан	30
4	Сүхбаатар	30
5	Хан-Уул	30
6	Чингэлтэй	30
Нийт		180

### 1.5 Судалгааны хамрах хүрээ, хязгаарлалт

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг үнэлэх хэрэглэгчийн үнэлгээний судалгааг 21 аймаг, нийслэлийн 6 дүүргийн хэмжээнд хязгаарыг тогтоож, 2017 онд цагдаагийн байгууллагаар үйлчлүүлсэн иргэдийн дунд судалгааг явуулсан. Улаанбаатар хотын хэрэглэгчийн үнэлгээг тодорхойлох судалгаа хугацаанаас хожимдож эхэлсэнтэй холбоотойгоор зөвхөн төвийн 6 дүүргийн иргэдийг хамруулан судалгааг явуулсан. Улаанбаатар хотын 6 дүүрэгт нийт 14 цагдаагийн хэлтэс үйл ажиллагаа явуулж байгаа ба дүүрэг бүрийн гэр, байшин хорооллоос судалгаанд оролцогчдыг төлөөлүүлэн сонгож авсан. Тиймээс тайланд дурдагдсан нийслэлийн дүүргүүдийн дүн нь хэлтэс тус бүрээрээ гараагүй болно.

Нийт судалгаанд оролцсон иргэдийн хүйсийн харьцааг Улаанбаатар хотоор тодорхойлж үзлээ. /Хүснэгт №1/

### Судалгаанд хамрагдсан иргэдийн хүйсийн харьцаа /бүсээр/

*Хүснэгт №2*

№	Бүсүүд	Судалгаанд хамрагдсан тоо				Дүн	Эзлэх хувь
		эрэгтэй		эмэгтэй			
		тоо	хувь	тоо	хувь		
5	Улаанбаатар хот	105	28.5	73	16.4	<b>178</b>	<b>22.0</b>

### 2.6 Улаанбаатар хотын судалгаанд хамрагдсан иргэдийн ерөнхий статистик мэдээлэл

Улаанбаатар хотын 6 дүүргийн 178 иргэд судалгаанд хамрагдсан ба Баянзүрх, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүрэг тус бүрээс 30 иргэн, Баянгол дүүргийн 33 иргэн, Сонгинохайрхан дүүргийн 25 иргэн судалгаанд оролцсон.

Судалгаанд хамрагдсан иргэдийн ерөнхий мэдээллийг нийт 7 бүлгийн 2 нээлттэй хариулт, 24 сонголттой хариултаар явуулсан.

### Улаанбаатар хотын судалгаанд хамрагдсан иргэдийн шинж байдал, тоогоор

Үзүүлэлт	Шинж байдал	Судалгаанд хамрагдсан иргэдийн тоо						Нийт дүн
		Баянгол дүүрэг	Баянзүрх дүүрэг	Сонгино-хайрхан дүүрэг	Сүхбаатар дүүрэг	Хан-Уул дүүрэг	Чингэлтэй дүүрэг	
Хүйс	Эрэгтэй	20	13	16	13	25	18	105
	Эмэгтэй	13	17	9	17	5	12	73
Гэрлэлтийн байдал	Ганц бие	12	7	6	3	10	9	47
	Гэрлэсэн	20	21	19	26	19	19	124
	Бэлэвсэн	1	2	-	1	1	2	7
Нас	24 - доош	9	1	4	4	5	5	28
	25 - 34	14	12	14	10	13	9	72
	35 - 44	5	10	7	10	8	4	44
	45 - 54	4	5	-	4	1	6	20
	55 - дээш	1	2	-	2	3	6	14
Боловсролын байдал	Боловсролгүй	-	-	-	-	1	-	1
	Бага	-	1	-	-	1	-	2
	Бүрэн бус дунд	7	4	1	4	8	11	35
	Бүрэн дунд	7	10	12	6	11	10	56
	Дээд	19	15	12	20	9	9	84
Сууцны төрөл	Гэрт	8	12	9	12	13	6	60
	Байшинд	4	10	10	4	8	13	49
	Орон сууц	7	6	2	11	4	7	37
	Зээлийн орон сууц	5	1	1	1	2	1	11
	Түрээсийн байр	9	1	3	2	3	3	21
	500.000 – доош	4	4	2	4	7	9	30
Гэр бүлийн гишүүдийн сарын орлого	500.000-1.000.000	9	13	6	11	9	10	58
	1.000.000 – 2.000.000	12	2	1	4	13	5	37
	2.000.000 – 3.000.000	-	3	3	3	-	2	11
	3.000.000 – 4.000.000	3	2	2	2	-	1	10
	4.000.000 – 5.000.000	2	1	3	2	-	-	8
	5.000.000 – 6.000.000	-	3	5	2	-	1	11
	6.000.000 – 7.000.000	2	-	1	-	-	-	3
	7.000.000 - дээш	1	2	2	2	1	2	10

Эх үүсвэр: Судлаачийн SPSS 21 програмаар тооцсон дүн

### 3. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ЧИГ ҮҮРГИЙН ТАЛААР

3.6. Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн талаар сэтгэл ханамжийн үнэлгээ

Улаанбаатар хотын 6 дүүргийн 178 иргэд судалгаанд хамрагдсан ба Баянзүрх, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүрэг тус бүрээс 30 иргэн, Баянгол дүүргийн 33 иргэн, Сонгинохайрхан дүүргийн 25 иргэн судалгаанд оролцсон. Цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн талаарх иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээг нийт 8 асуултаар явуулсан. Асуултанд хариулсан хариултын сонголтыг 1-5 хүртэлх тоон үнэлгээгээр үнэлж судалгааг авсан.

## Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүрэг /дүүргээр/

Хүснэгт №4.

Дүүргээр	Цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн талаар				
	Цагдаагийн байгууллагад гэмт хэргийн талаар дуудлага, мэдээлэл өгсөн тохиолдолд аль болох богино хугацаанд хүрэлцэн ирдэг	Гэмт хэрэг үйлдэгдсэн талаар цагдаагийн байгууллагад мэдээлсэн тохиолдолд гэмт этгээдийг заавал олж баривчилдаг	Ноцтой гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цагдаагийн байгууллага түргэн шуурхай илрүүлдэг	Цагдаагийн алба хаагчид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хангалттай зохион байгуулдаг бөгөөд үр дүнтэй байдаг	Орон нутгийн хэмжээнд гэмт хэргийг таслан зогсоох ажиллагааг цагдаа үр дүнтэй хэрэгжүүлдэг
Баянгол	3.48	3.33	3.55	<b>3.03</b>	<b>3.15</b>
Баянзүрх	<b>4.00</b>	3.37	3.63	3.37	3.37
Сонгинохайрхан	<b>3.44</b>	<b>3.28</b>	3.56	3.48	<b>3.60</b>
Сүхбаатар	3.73	<b>3.80</b>	<b>4.30</b>	3.43	3.53
Хан-Уул	3.97	3.60	3.87	3.60	3.50
Чингэлтэй	3.63	3.37	3.60	<b>3.80</b>	3.53
<b>Ерөнхий дундаж</b>	<b>3.70</b>	<b>3.45</b>	<b>3.75</b>	<b>3.45</b>	<b>3.44</b>

Тайлбар: Огт санал нийлэхгүй – 1, Санал нийлэхгүй – 2, Дунд зэрэг – 3, Санал нийлнэ – 4, Бүрэн санал нийлнэ - 5

Дээрх хүснэгтээс харахад судалгаанд оролцогсдын **“Цагдаагийн байгууллагад гэмт хэргийн талаар дуудлага, мэдээлэл өгсөн тохиолдолд аль болох богино хугацаанд хүрэлцэн ирдэг”** гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 3.70 байсан ба дунджаас дээгүүр Баянзүрх, Сүхбаатар, Хан-Уул дүүргийн иргэд хариулт өгсөн бол Баянгол, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн иргэд дунджаас доогуур үнэлгээ өгсөн байна.

**“Гэмт хэрэг үйлдэгдсэн талаар цагдаагийн байгууллагад мэдээлсэн тохиолдолд гэмт этгээдийг заавал олж баривчилдаг”** гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 3.45 байсан ба дунджаас дээгүүр Сүхбаатар, Хан-Уул дүүргийн иргэд хариулт өгсөн бол Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн иргэд дунджаас доогуур үнэлгээ өгсөн байна.

**“Ноцтой гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цагдаагийн байгууллага түргэн шуурхай илрүүлдэг”** гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 3.75 байсан ба дунджаас дээгүүр Сүхбаатар, Хан-Уул дүүргийн иргэд хариулсан бол Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн иргэд дунджаас доогуур үнэлгээ өгсөн байна.

**“Цагдаагийн алба хаагчид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хангалттай зохион байгуулдаг бөгөөд үр дүнтэй байдаг”** гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 3.45 бөгөөд дунджаас дээгүүр Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн иргэд хариулсан бол Баянгол, Баянзүрх, Сүхбаатар дүүргийн иргэд дунджаас доогуур хариулсан байна.

**“Орон нутгийн хэмжээнд гэмт хэргийг таслан зогсоох ажиллагааг цагдаа үр дүнтэй хэрэгжүүлдэг”** гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 3.44 бөгөөд дунджаас дээгүүр Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн иргэд хариулсан бол Баянгол, Баянзүрх дүүргийн иргэд дунджаас доогуур үнэлгээ өгсөн байна.

## Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүрэг /дүүргээр/

Хүснэгт №5.

үргэлжилэл

Дүүргээр	Цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн талаар				
	Цагдаагийн алба хаагч хэв журам сахиулах зорилгоор манай нутаг дэвсгэрт эргүүлийн үүрэг маш сайн гүйцэтгэдэг	Цагдаа орон нутгийн хэмжээнд зохион байгуулдаг олон нийтийг хамарсан спорт, урлаг, баяр наадам, жагсаал цуглааныг зохицуулах, аюулгүй байдлыг хангах үүргээ сайн гүйцэтгэдэг	Цагдаагийн алба хаагч замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажиллагааг мэргэжлийн түвшинд үр дүнтэй хэрэгжүүлдэг	Дундаж	Стандарт хазайлт
Баянгол	3.64	4.00	3.67	3.48	0.96
Баянзүрх	3.57	3.60	3.50	3.55	1.18
Сонгинохайрхан	3.40	3.60	3.52	3.48	0.77
Сүхбаатар	3.63	4.20	3.97	3.82	0.89
Хан-Уул	3.97	3.90	3.63	3.75	0.85
Чингэлтэй	3.73	3.73	3.80	3.64	1.03
<b>Ерөнхий дундаж</b>	<b>3.65</b>	<b>3.83</b>	<b>3.68</b>	<b>3.62</b>	<b>0.94</b>


Тайлбар: Огт санал нийлэхгүй – 1, Санал нийлэхгүй – 2, Дунд зэрэг – 3, Санал нийлнэ – 4, Бүрэн санал нийлнэ - 5

“Цагдаагийн алба хаагч хэв журам сахиулах зорилгоор манай нутаг дэвсгэрт эргүүлийн үүрэг маш сайн гүйцэтгэдэг” гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 3.65 бөгөөд дунджаас дээгүүр Хан-Уул, Чингэлтэй дүүргийн иргэд хариулсан бол Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргийн иргэд дунджаас доогуур үнэлгээ өгсөн байна.

“Цагдаа орон нутгийн хэмжээнд зохион байгуулдаг олон нийтийг хамарсан спорт, урлаг, баяр наадам, жагсаал цуглааныг зохицуулах, аюулгүй байдлыг хангах үүргээ сайн гүйцэтгэдэг” гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 3.83 бөгөөд дунджаас дээгүүр Баянгол, Сүхбаатар, Хан-Уул дүүргийн иргэд хариулсан бол Баянзүрх, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн иргэд дунджаас доогуур үнэлгээ өгсөн байна.

“Цагдаагийн алба хаагч замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажиллагааг мэргэжлийн өндөр түвшинд үр дүнтэй хэрэгжүүлдэг” гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 3.68 бөгөөд дунджаас дээгүүр Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэд хариулсан бол Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн иргэд дунджаас доогуур үнэлгээ өгсөн байна.

Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн үнэлгээ, дүүргээр





#### 4. ХУУЛЬ ЁСНЫ БАЙДАЛ

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн. Тиймээс Цагдаагийн алба хаагч үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль, тогтоомжийг мөрдлөг болгон ажиллах үүрэгтэй. Орон нутгийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь хууль ёсны байдлыг үнэлсэн.

Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын хууль ёсны байдлын талаар иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ

Улаанбаатар хотын 6 дүүргийн 178 иргэд судалгаанд хамрагдсан ба Баянзүрх, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүрэг тус бүрээс 30 иргэн, Баянгол дүүргийн 33 иргэн, Сонгинохайрхан дүүргийн 25 иргэн судалгаанд оролцсон. Орон нутгийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь хууль ёсны байдлын талаарх иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээг нийт 7 асуултаар явуулсан. Асуултанд хариулсан хариултын сонголтыг 1-5 хүртэлх тоон үнэлгээгээр үнэлж судалгааг авсан.

#### Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын хууль ёсны байдлын үнэлгээ /дүүргээр/

Хүснэгт №6.

Дүүргээр	Орон нутгийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь хууль ёсны байдлынталаар								
	Цагдаагийн байгууллага иргэдээс хүлээн авсан гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг хуулийн дагуу шуурхай шийдвэрлэж, хариу өгдөг	Цагдаагийн алба хаагчид үйл ажиллагаандаа хуулийг баримтлан шударга ёсыг эрхэмлэн ажилладаг	Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа ил тод, эргэлзээгүй байдаг	Цагдаагийн байгууллагаас надтай холбоотой асуудлаар гаргасан шийдвэр нь хууль ёсны бөгөөд миний ашиг сонирхолд нийцдэг	Манай орон нутагт ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчид авилга, хээл хахуулиас ангид ажилладаг	Цагдаагийн алба хаагч үйл ажиллагаа явуулахдаа хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн ажилладаг	Гэмт хэрэг үйлдсэн, эсхүл сэрдлэгдсэн болон тэдний гэр бүлийн гишүүдтэй цагдаагийн алба хаагч хуулийн дагуу харьддаг	Дундаж	Стандарт хазайлт
Баянгол	3.30	<b>3.21</b>	3.00	3.18	3.27	3.21	3.33	<b>3.21</b>	<b>1.06</b>
Баянзүрх	<b>3.00</b>	3.27	<b>2.93</b>	<b>2.90</b>	3.30	3.23	3.50	<b>3.16</b>	<b>1.09</b>
Сонгинохайрхан	3.36	3.48	3.24	3.40	3.28	3.44	<b>3.20</b>	<b>3.34</b>	<b>0.92</b>
Сүхбаатар	<b>3.70</b>	<b>3.83</b>	<b>3.73</b>	3.40	<b>4.00</b>	<b>3.90</b>	<b>3.87</b>	<b>3.77</b>	<b>0.91</b>
Хан-Уул	3.43	3.30	3.27	3.40	<b>3.17</b>	<b>3.03</b>	3.70	<b>3.32</b>	<b>0.95</b>
Чингэлтэй	3.47	3.70	3.30	<b>3.60</b>	3.63	3.57	3.80	<b>3.58</b>	<b>1.00</b>
<b>Ерөнхий дундаж</b>	<b>3.37</b>	<b>3.46</b>	<b>3.24</b>	<b>3.31</b>	<b>3.44</b>	<b>3.39</b>	<b>3.56</b>	<b>3.39</b>	<b>0.98</b>

Тайлбар: Огт санал нийлэхгүй – 1, Санал нийлэхгүй – 2, Дунд зэрэг – 3, Санал нийлнэ – 4, Бүрэн санал нийлнэ - 5

Дээрх хүснэгтээс харахад судалгаанд оролцогчдын “Цагдаагийн байгууллага иргэдээс хүлээн авсан гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг хуулийн дагуу шуурхай шийдвэрлэж, хариу өгдөг” гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 3.37 бөгөөд

дунджаас дээгүүр Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн иргэд хариулсан бол Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн иргэд дунджаас доогуур үнэлгээ өгсөн байна.

**“Цагдаагийн алба хаагчид үйл ажиллагаандаа хуулийг баримтлан шударга ёсыг эрхэмлэн ажилладаг”** гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 3.46 бөгөөд дунджаас дээгүүр Сүхбаатар, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн иргэд хариулсан бол Баянгол, Баянзүрх, Хан-Уул дүүргийн иргэд дунджаас доогуур үнэлгээ өгсөн байна.

**“Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа ил тод, эргэлзээгүй байдаг”** гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 3.24 бөгөөд дунджаас дээгүүр Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн иргэд хариулсан бол Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн иргэд дунджаас доогуур үнэлгээ өгсөн байна.

**“Цагдаагийн байгууллагаас надтай холбоотой асуудлаар гаргасан шийдвэр нь хууль ёсны бөгөөд миний ашиг сонирхолд нийцдэг”** гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 3.31 бөгөөд дунджаас дээгүүр Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн иргэд хариулсан бол Баянгол, Баянзүрх дүүргийн иргэд дунджаас доогуур үнэлгээ өгсөн байна.


**“Манай орон нутагт ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчид авилга, хээл хахуулиас ангид ажилладаг”** гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 3.44 бөгөөд дунджаас дээгүүр Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэд хариулсан бол Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн иргэд дунджаас доогуур үнэлгээ өгсөн байна.

**“Цагдаагийн алба хаагч үйл ажиллагаа явуулахдаа хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн ажилладаг** гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 3.39 бөгөөд дунджаас дээгүүр Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэд хариулсан бол Баянгол, Баянзүрх, Хан-Уул дүүргийн иргэд дунджаас доогуур үнэлгээ өгсөн байна.

**“Гэмт хэрэг үйлдсэн, эсхүл сэрдэгдсэн болон тэдний гэр бүлийн гишүүдтэй цагдаагийн алба хаагч хуулийн дагуу харьцдаг”** гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 3.56 бөгөөд дунджаас дээгүүр Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн иргэд хариулсан бол Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн аймгийн иргэд дунджаас доогуур үнэлгээ өгсөн байна.

Ерөнхий стандарт хазайлт 0.98 байгаа нь алдаа бага байгааг илэрхийлнэ. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь хууль ёсны байдлын талаарх сэтгэл ханамжийн Улаанбаатар хотын дундаж үнэлгээг зургаар илэрхийлье.

Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын хууль ёсны байдлын үнэлгээ, дүүргээр



## 5. ОРОН НУТГИЙН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монгол Улсын Үндсэн Хуульд зааснаар хүн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхтэй бөгөөд энэ эрхийг хангахад цагдаагийн байгууллага тодорхой үүрэг хүлээдэг. Иргэдийн аюулгүй, тайван амьдрах эсэх нь тэдний оршин сууж байгаа нутаг дэвсгэрийн орчны аюулгүй байдал, тохижилтоос хамаарна.

### Улаанбаатар хотын орон нутгийн нөхцөл байдлын талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ

Улаанбаатар хотын 6 дүүргийн 178 иргэд судалгаанд хамрагдсан ба Баянзүрх, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүрэг тус бүрээс 30 иргэн, Баянгол дүүргийн 33 иргэн, Сонгинохайрхан дүүргийн 25 иргэн судалгаанд оролцсон. Иргэдийн аюулгүй, тайван амьдрах нь орон нутгийн нөхцөл байдлаас хамаардаг талаарх иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээг нийт 8 асуултаар явуулсан. Асуултанд хариулсан хариултын сонголтыг 1-5 хүртэлх тоон үнэлгээгээр үнэлж судалгааг авсан.

### Улаанбаатар хотын нөхцөл байдлын үнэлгээ, дүүргээр

Хүснэгт №8.

Дүүргээр	Орон нутгийн нөхцөл байдлын үнэлгээ								Дундаж	Стандарт хазайлт
	Миний оршин сууж буй нутаг дэвсгэр орчны бохирдол, хог хаягдал ихтэй	Харанхуй, гэрэлтүүлэг муутай болон ганцаараа явахад айдас төрөхүйц газар олон байдаг	Хүн орогнох боломжтой эзэнгүй, хоосон байшин, орц хонгил, хаягдал машин болон гяаж гэх мэт зүйлс байдаг	Замын хөдөлгөөний дүрэм зөрчих, бие засах, оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулах, хоорондоо маргалдах гэх мэт нийгмийн хэв журам зөрчдөг хүн олон байдаг	Гэмт хэрэг үйлдэж болзошгүй, гэнэмэл болон архичдын бүлэг, бөөгнөрлийг байнга хардаг	Авто замын нөхцөл байдал, гэрлэн дохио, замын тэмдэглэгээ сайн хийгдсэн	Гудамж талбай, нийтийн эзэмшлийн газар бүрэн камержуулалтын системд холбогдсон	Центрлэгт хүрээлэн, биеийн тамирын талбай, хүүхдийн тоглоомын газар зэрэг оршин суугчдын чөлөөт цагаа өнгөрүүлэх газар хангалттай байдаг		
Баянгол	3.76	3.64	3.42	3.94	3.61	3.52	2.82	2.58	3.41	1.01
Баянзүрх	3.40	3.53	3.07	3.57	3.43	3.10	2.43	2.17	3.08	1.10
Сонгинохайрхан	3.32	3.48	3.28	3.60	3.80	3.60	3.12	2.72	3.36	0.89
Сүхбаатар	3.57	3.77	3.43	3.40	3.63	3.50	3.17	2.73	3.40	1.08
Хан-Уул	3.63	3.40	3.37	3.83	3.53	3.57	2.60	2.57	3.31	1.17
Чингэлтэй	3.23	3.63	3.20	3.63	3.47	3.83	2.93	2.53	3.30	1.07
<b>Ерөнхий дундаж</b>	<b>3.48</b>	<b>3.57</b>	<b>3.29</b>	<b>3.66</b>	<b>3.57</b>	<b>3.52</b>	<b>2.84</b>	<b>2.55</b>	<b>3.31</b>	<b>1.05</b>

Тайлбар: Огт санал нийлэхгүй – 1, Санал нийлэхгүй – 2, Дунд зэрэг – 3, Санал нийлнэ – 4, Бүрэн санал нийлнэ - 5

Дээрх хүснэгтээс харахад судалгаанд оролцогчдын “Миний оршин сууж буй нутаг дэвсгэр орчны бохирдол, хог хаягдал ихтэй” гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 3.48 бөгөөд дунджаас дээгүүр Баянгол, Сүхбаатар, Хан-Уул дүүргийн иргэд хариулсан бол Баянзүрх, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн иргэд дунджаас доогуур үнэлгээ өгсөн байна.

“Харанхуй, гэрэлтүүлэг муутай болон ганцаараа явахад айдас төрөхүйц газар олон байдаг” гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 3.57 бөгөөд дунджаас дээгүүр

Баянгол, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэд хариулсан бол Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн иргэд дунджаас доогуур үнэлгээ өгсөн байна.

**“Хүн орогнох боломжтой эзэнгүй, хоосон байшин, орц хонгил, хаягдал машин болон граж гэх мэт зүйлс байдаг”** гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 3.29 бөгөөд дунджаас дээгүүр Баянгол, Сүхбаатар, Хан-Уул дүүргийн иргэд хариулсан бол Баянзүрх, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн иргэд дунджаас доогуур үнэлгээ өгсөн байна.

**“Замын хөдөлгөөний дүрэм зөрчих, бие засах, оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулах, хоорондоо маргалдах гэх мэт нийгмийн хэв журам зөрчдөг хүн олон байдаг”** гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 3.66 бөгөөд дунджаас дээгүүр Баянгол, Хан-Уул дүүргийн иргэд хариулсан бол Баянзүрх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн иргэд дунджаас доогуур үнэлгээ өгсөн байна.

**“Гэмт хэрэг үйлдэж болзошгүй, тэнэмэл болон архичдын бүлэг, бөөгнөрлийг байнга хардаг”** гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 3.57 бөгөөд дунджаас дээгүүр Баянгол, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргийн иргэд хариулсан бол Баянзүрх, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн иргэд дунджаас доогуур үнэлгээ өгсөн байна.


**“Авто замын нөхцөл байдал, гэрлэн дохио, замын тэмдэглэгээ сайн хийгдсэн”** гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 3.52 бөгөөд дунджаас дээгүүр Баянгол, Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн иргэд хариулсан бол Сүхбаатар, Баянзүрх дүүргийн иргэд дунджаас доогуур үнэлгээ өгсөн байна.

**“Гудамж талбай, нийтийн эзэмшлийн газар бүрэн камержуулалтын системд холбогдсон”** гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 2.84 бөгөөд дунджаас дээгүүр Сүхбаатар, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн иргэд хариулсан бол Баянгол, Баянзүрх, Хан-Уул дүүргийн иргэд дунджаас доогуур үнэлгээ өгсөн байна.

**“Цэцэрлэгт хүрээлэн, биеийн тамирын талбай, хүүхдийн тоглоомын газар зэрэг оршин суугчдын чөлөөт цагаа өнгөрүүлэх газар хангалттай байдаг”** гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 2.55 бөгөөд дунджаас дээгүүр Баянгол, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул дүүргийн иргэд хариулсан бол Баянзүрх, Чингэлтэй дүүргийн иргэд дунджаас доогуур үнэлгээ өгсөн байна.

Ерөнхий стандарт хазайлт 1.05 байгаа нь алдаа байгааг илэрхийлнэ. Орон нутгийн ерөнхий нөхцөл байдлын талаарх сэтгэл ханамжийг Улаанбаатар хотын дундаж үнэлгээг зургаар илэрхийлье.

Улаанбаатар хотын ерөнхий нөхцөл байдлын үнэлгээ, дүүргээр



## 6. ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧДЫН ХАРИЛЦААНЫ СОЁЛ, ЁС ЗҮЙН ТӨЛӨВШИЛ

Доорх асуултууд нь таны оршин сууж буй нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын алба хаагчдын ёс зүй, харилцааны соёлыг тодорхойлоход чиглэгдэнэ.

### 6.6 Улаанбаатар хотын цагдаагийн алба хаагчдын соёл, ёс зүйн төлөвшилтийн талаар сэтгэл ханамжийн үнэлгээ

Улаанбаатар хотын 6 дүүргийн 178 иргэд судалгаанд хамрагдсан ба Баянзүрх, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүрэг тус бүрээс 30 иргэн, Баянгол дүүргийн 33 иргэн, Сонгинохайрхан дүүргийн 25 иргэн судалгаанд оролцсон. Цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшилтийн талаарх сэтгэл ханамжийн үнэлгээг нийт 6 асуултаар явуулсан. Асуултанд хариулсан хариултын сонголтыг 1-5 хүртэлх тоон үнэлгээгээр үнэлж судалгааг авсан.

### Улаанбаатар хотын цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшилтийн үнэлгээ, дүүргээр

Дүүргээр	Цагдаагийн алба хаагчдын соёл, ёс зүйн төлөвшилтийн талаар							Дундаж	Стандарт хазайлт
	Алба хаагчид харилцааны өндөр той, стандарт дүрмээ баримтлан ажилладаг	Агийн алба хаагчаас мэдээлэл авах, тан ойлголцоход хялбархан байдаг	Агийн байгууллагын алба хаагчид нийтийн газар биеэ зөв авч явж, бусдад үлгэр дуурайл үзүүлдэг	Цагдаагийн алба хаагчид иргэдэд тэтгэлтэй хандаж, тэдэнд тулгарсан асуудлыг шийдвэрлэхэд бэлэн байдаг	Агийн алба хаагчийн мэргэжлийн дэдлэг, ур чадвар хангалттай	Цагдаагийн алба хаагчид нийгмийн гэрээний гишүүд, ахмад настай иргэд, хүүхдэд илүү хүндэтгэлтэй ханддаг			
Баянгол	<b>2.79</b>	3.24	<b>3.33</b>	3.33	<b>3.18</b>	3.42	<b>3.12</b>	<b>0.87</b>	
Баянзүрх	3.03	3.27	3.50	3.37	3.60	3.57	<b>3.37</b>	<b>1.02</b>	
Сонгинохайрхан	3.48	<b>3.20</b>	3.44	3.24	3.40	3.48	<b>3.37</b>	<b>0.87</b>	
Сүхбаатар	<b>3.53</b>	<b>3.83</b>	<b>3.90</b>	<b>3.87</b>	<b>3.80</b>	<b>4.10</b>	<b>3.83</b>	<b>0.86</b>	
Хан-Уул	2.90	3.27	3.37	<b>3.10</b>	3.40	<b>3.37</b>	<b>3.23</b>	<b>1.00</b>	
Чингэлтэй	3.63	3.53	3.70	3.37	<b>3.80</b>	3.70	<b>3.62</b>	<b>0.93</b>	
<b>Ерөнхий дундаж</b>	<b>3.22</b>	<b>3.39</b>	<b>3.54</b>	<b>3.38</b>	<b>3.53</b>	<b>3.60</b>	<b>3.42</b>	<b>0.92</b>	

Тайлбар: Огт санал нийлэхгүй – 1, Санал нийлэхгүй – 2, Дунд зэрэг – 3, Санал нийлнэ – 4, Бүрэн санал нийлнэ - 5

Дээрх хүснэгтээс харахад судалгаанд оролцогчдын “Алба хаагчид харилцааны өндөр соёлтой, стандарт дүрмээ баримтлан ажилладаг” гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 3.22 бөгөөд дунджаас дээгүүр Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэд хариулсан бол Баянгол, Баянзүрх, Хан-Уул дүүргийн иргэд дунджаас доогуур үнэлгээ өгсөн байна.

“Цагдаагийн алба хаагчаас мэдээлэл авах, харилцан ойлголцоход хялбархан байдаг” гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 3.39 бөгөөд дунджаас дээгүүр Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэд хариулсан бол Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн иргэд дунджаас доогуур үнэлгээ өгсөн байна.

“Цагдаагийн байгууллагын алба хаагчид олон нийтийн газар биеэ зөв авч явж, бусдад үлгэр дуурайл үзүүлдэг” гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 3.54 бөгөөд дунджаас дээгүүр

Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэд хариулсан бол Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн иргэд дунджаас доогуур үнэлгээ өгсөн байна.

**“Цагдаагийн алба хаагчид иргэдэд хүндэтгэлтэй хандаж, тэдэнд тулгарсан асуудлыг шийдвэрлэхэд бэлэн байдаг”** гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 3.38 бөгөөд дунджаас дээгүүр Сүхбаатар дүүргийн иргэд хариулсан бол Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн иргэд дунджаас доогуур үнэлгээ өгсөн байна.


**“Цагдаагийн алба хаагчийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар хангалттай”** гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 3.53 бөгөөд дунджаас дээгүүр Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэд хариулсан бол Баянгол, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн иргэд дунджаас доогуур үнэлгээ өгсөн байна.

**“Цагдаагийн алба хаагчид нийгмийн эмзэг бүлгийн гишүүд, ахмад настай хүмүүс, хүүхдэд илүү хүндэтгэлтэй ханддаг”** гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 3.60 бөгөөд дунджаас дээгүүр Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэд хариулсан бол Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн иргэд дунджаас доогуур үнэлгээ өгсөн байна.

Ерөнхий стандарт хазайлт 0.92 байгаа нь алдаа бага байгааг илэрхийлнэ. Цагдаагийн алба хаагчдын соёл, ёс зүйн төлөвшилтийн сэтгэл ханамжийг Улаанбаатар хотын дундаж үнэлгээг зургаар илэрхийлье.



Улаанбаатар хогын цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшилтийн үнэлгээ /дүүргээр/



## 7. ГЭМТ ХЭРГЭЭС СЭРЭМЖЛЭХ ЕРӨНХИЙ ХАНДЛАГА

Ямар нөхцөл байдалд айдасыг хир зэрэг мэдэрдэг эсэхийг тогтоох зорилготой.

### Улаанбаатар хотын гэмт хэргээс сэрэмжлэх ерөнхий хандлагын талаар сэтгэл ханамжийн үнэлгээ

Улаанбаатар хотын 6 дүүргийн 178 иргэд судалгаанд хамрагдсан ба Баянзүрх, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүрэг тус бүрээс 30 иргэн, Баянгол дүүргийн 33 иргэн, Сонгинохайрхан дүүргийн 25 иргэн судалгаанд оролцсон. Гэмт хэргээс сэрэмжлэх ерөнхий хандлагын талаарх иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээг нийт 4 асуултаар явуулсан. Асуултанд хариулсан хариултын сонголтыг 1-5 хүртэлх тоон үнэлгээгээр үнэлж судалгааг авсан.

### Улаанбаатар хотын гэмт хэргээс сэрэмжлэх ерөнхий хандлагын үнэлгээ, дүүргээр

Дүүргээр	Гэмт хэргээс сэргийлэх ерөнхий хандлагын талаар					
	Оройн цагаар гэртээ ганцаараа байх үед	Оршин суудаг газартаа шөнийн цагаар ганцаараа алхах үед	Миний хүүхэд, гэр бүлийн гишүүд оройтож гэртээ ирэх үед	Олон нийтийн газарт мөнгө, эд зүйлс авч явах үедээ хулгайд алдах, дээрэмдүүлж болзошгүй үед	Дундаж	Стандарт хазайлт
Баянгол	2.70	3.39	3.70	3.79	3.39	0.93
Баянзүрх	2.50	3.23	3.63	3.50	3.21	1.16
Сонгинохайрхан	3.12	3.28	3.68	3.44	3.38	1.10
Сүхбаатар	2.83	3.00	3.37	3.60	3.20	1.04
Хан-Уул	2.67	3.00	3.60	3.70	3.24	1.03
Чингэлтэй	2.50	3.00	3.40	3.37	3.06	1.10
<b>Ерөнхий дундаж</b>	<b>2.72</b>	<b>3.15</b>	<b>3.56</b>	<b>3.56</b>	<b>3.24</b>	<b>1.06</b>

Тайлбар: Огт айдасгүй байдаг-1, Айдасгүй байдаг- 2, Дунд зэрэг - 3, Айдастай байдаг - 4, Их айдастай байдаг - 5

Дээрх хүснэгтээс харахад судалгаанд оролцогчдын **“Оройн цагаар гэртээ ганцаараа байх үед”** гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 2.72 бөгөөд дунджаас дээгүүр буюу айдастай гэж Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргийн иргэд хариулсан бол Баянгол, Баянзүрх, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн иргэд дунджаас доогуур буюу айдас багатай гэсэн үнэлгээ өгсөн байна.


**“Оршин суудаг газартаа шөнийн цагаар ганцаараа алхах үед”** гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 3.15 бөгөөд дунджаас дээгүүр буюу айдастай гэж Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн иргэд хариулсан бол Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн иргэд дунджаас доогуур буюу айдас багатай гэсэн үнэлгээ өгсөн байна.

**“Миний хүүхэд, гэр бүлийн гишүүд оройтож гэртээ ирэх үед”** гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 3.56 бөгөөд дунджаас дээгүүр буюу айдастай гэж Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн иргэд хариулсан бол Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэд дунджаас доогуур буюу айдас багатай гэсэн үнэлгээ өгсөн байна.

**“Олон нийтийн газарт мөнгө, эд зүйлс авч явах үедээ хулгайд алдах эсхүл дээрэмдүүлж болзошгүй үед”** гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 3.56 бөгөөд дунджаас дээгүүр буюу айдастай гэж Баянгол, Сүхбаатар, Хан-Уул дүүргийн иргэд хариулсан бол Баянзүрх, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн иргэд дунджаас доогуур буюу айдас багатай гэсэн үнэлгээ өгсөн байна.

Ерөнхий стандарт хазайлт 1.06 байгаа нь алдаа байгааг илэрхийлнэ. Гэмт хэргээс сэргийлэх ерөнхий хандлагыг Улаанбаатар хотын дундаж үнэлгээг зургаар илэрхийлье.

### Улаанбаатар хотын гэмт хэргээс сэрэмжлэх ерөнхий хандлагын үнэлгээ /дүүргээр/



## 8. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ СЭТГЭЛ ХАНАМЖ

Энэ хэсэг цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь иргэдийн сэтгэл ханамжийг тодорхойлоход чиглэгдэнэ.

### 8.6 Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны сэтгэл ханамжийн судалгаа

Улаанбаатар хотын 6 дүүргийн 178 иргэн судалгаанд хамрагдсан ба Баянзүрх, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүрэг тус бүрээс 30 иргэн, Баянгол дүүргийн 33 иргэн, Сонгинохайрхан дүүргийн 25 иргэн судалгаанд оролцсон. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээг нийт 3 асуултаар явуулсан. Асуултанд хариулсан хариултын сонголтыг 1-5 хүртэлх тоон үнэлгээгээр үнэлж судалгааг авсан.

### Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь сэтгэл ханамжийн үнэлгээ /дүүргээр/

Дүүргээр	Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаар				
	Би цагдаагийн байгууллагад хандаж үйлчлүүлээд сэтгэл ханамж өндөр байсан	Би эсхүл миний гэр бүлийн гишүүд гэмт хэрэг, халдлагад өртсөн тохиолдолд эргэлзээгүйгээр цагдаагийн байгууллагад ханддаг	Манай цагдаа намайг хамгаална гэж би итгэдэг	Дундаж	Стандарт хазайлт
Баянгол	3.03	4.00	3.33	3.45	0.78
Баянзүрх	3.30	4.20	3.70	3.73	0.93
Сонгинохайрхан	3.08	3.92	3.36	3.45	0.85
Сүхбаатар	3.67	4.23	4.13	4.01	0.86
Хан-Уул	3.00	4.07	3.77	3.61	0.99
Чингэлтэй	3.53	3.93	4.00	3.82	0.92
<b>Ерөнхий дундаж</b>	<b>3.26</b>	<b>4.05</b>	<b>3.71</b>	<b>3.67</b>	<b>0.88</b>

Тайлбар: Огт санал нийлэхгүй – 1, Санал нийлэхгүй – 2, Дунд зэрэг – 3, Санал нийлнэ – 4, Бүрэн санал нийлнэ – 5

Дээрх хүснэгтээс харахад судалгаанд оролцогчдын “Би цагдаагийн байгууллагад хандаж үйлчлүүлээд сэтгэл ханамж өндөр байсан” гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 3.26


бөгөөд дунджаас дээгүүр Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэд хариулсан бол Баянгол, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн иргэд дунджаас доогуур үнэлгээ өгсөн байна.

“Би эсхүл миний гэр бүлийн гишүүд гэмт хэрэг, халдлагад өртсөн тохиолдолд ямар ч эргэлзээгүйгээр цагдаагийн байгууллагад ханддаг” гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 4.05 бөгөөд дунджаас дээгүүр Баянзүрх, Сүхбаатар, Хан-Уул дүүргийн иргэд хариулсан бол Баянгол, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн иргэд дунджаас доогуур үнэлгээ өгсөн байна.

“Манай цагдаа намайг хамгаална гэж би итгэдэг” гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 3.71 бөгөөд дунджаас дээгүүр Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул дүүргийн иргэд хариулсан бол Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн иргэд дунджаас доогуур үнэлгээ өгсөн байна.

Ерөнхий стандарт хазайлт 0.88 байгаа нь алдаа бага байгааг илэрхийлнэ. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны сэтгэл ханамжийн Улаанбаатар хотын дундаж үнэлгээг зургаар илэрхийлье.

Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь сэтгэл ханамжийн үнэлгээ /дүүргээр/




## 9. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ТАЛААР ИРГЭДЭЭС АВСАН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ

Нийт судалгаанд хамрагдсан 4 бүс, Улаанбаатар хотын 810 иргэдээс 5 асуултын үнэлгээг дүүрэг, аймгаар байр эзлүүлсэн. -

Нийт 5 бүлгийн 32 асуултаар иргэдээс өгсөн дундаж үнэлгээ 3.25 байсан. 8 аймаг, 6 дүүрэг дунджаас дээгүүр үнэлгээ авсан бол 13 аймаг дунджаас доогуур үнэлгээ авсан байна. Байр эзлүүлж үзэхэд *нэгдүгээр байранд* Сүхбаатар дүүрэг, *хоёрдугаар байранд* Чингэлтэй аймаг, *гуравдугаар байранд* Хэнтий аймаг тус тус орсон байна. Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул, Сонгинохайрхан, Баянзүрх, Баянгол дүүрэг, Хэнтий, Увс, Орхон, Сэлэнгэ, Өвөрхангай, Завхан, Архангай, Дорноговь аймгууд дунджаас дээгүүр үнэлгээ авсан байна. Дундговь, Баянхонгор, Хөвсгөл, Дархан-Уул, Дорнод, Өмнөговь, Говьсүмбэр, Ховд, Сүхбаатар, Баян-Өлгий, Төв, Говь-Алтай, Булган аймгууд дунджаас доогуур үнэлгээ авсан байна.

Цагдаагийн байгууллагын талаар иргэдээс өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээ, улсын хэмжээнд, дунджаар




Иргэдээс өгсөн нийт сэтгэл ханамжийн үнэлгээг орон нутгаар 5 бүлгийн 32 асуултаар дүгнэж үзэхэд дундаж үнэлгээ **3.18** байсан. 10 аймаг дунджаас дээгүүр үнэлгээ авсан бол 11 аймаг дунджаас доогуур үнэлгээ авсан.

#### Цагдаагийн байгууллагын талаар иргэдээс өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээ /нийслэлд/

Иргэдээс өгсөн нийт сэтгэл ханамжийн үнэлгээг Улаанбаатар хотоор 5 бүлгийн 32 асуултаар дүгнэж үзэхэд дундаж үнэлгээ **3.48** байсан. 2 дүүрэг дунджаас дээгүүр үнэлгээ авсан бол 4 дүүрэг дунджаас доогуур үнэлгээ авсан.

#### Цагдаагийн байгууллагын талаар иргэдээс өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээ дүүргээр



Иргэдээс авсан санал асуулгаас гэмт хэргээс сэргийлэх ерөнхий хандлагын сэтгэл ханамжийн үнэлгээг 21 аймаг, 6 дүүргээр 4 асуултаар байр эзлүүлсэн.

**Улсын хэмжээнд гэмт хэргээс сэргийлэх ерөнхий хандлага, дунджаар, байраар**

Орон нутаг	Гэмт хэргээс сэрэмжлэх ерөнхий хандлага	Байр
Баян-Өлгий аймаг	2.85	I
Дорнод аймаг	2.87	II
Хэнтий аймаг	2.91	III
Говь-Алтай аймаг	2.95	IV
Орхон аймаг	2.96	V
Дундговь аймаг	2.97	VI
Говьсүмбэр аймаг	2.98	VII
Архангай аймаг	2.99	VIII
Өмнөговь аймаг	2.99	VIII
Увс аймаг	3.01	IX
Сүхбаатар аймаг	3.03	X
Чингэлтэй дүүрэг	3.06	XI
Завхан аймаг	3.08	XII
Өвөрхангай аймаг	3.10	XIII
Төв аймаг	3.16	XIV
Дархан-Уул аймаг	3.17	XV
Сүхбаатар дүүрэг	3.2	XVI
Баянзүрх дүүрэг	3.21	XVII
Дорноговь аймаг	3.23	XVIII
Хан-Уул дүүрэг	3.24	XIX
Ховд аймаг	3.27	XX
Баянхонгор аймаг	3.33	XXI
Сонгинохайрхан дүүрэг	3.38	XXII
Баянгол дүүрэг	3.39	XXIII
Хөвсгөл аймаг	3.47	XIV
Сэлэнгэ аймаг	3.5	XV
Булган аймаг	3.6	XVI

Дээрх хүснэгтээс харахад нийт 1 бүлгийн 4 асуултаар иргэдээс өгсөн дундаж үнэлгээ **3.14** байсан. 13 аймаг, 1 дүүрэг дунджаас доогуур үнэлгээ авсан бол 8 аймаг, 5 дүүргийн иргэд дунджаас дээгүүр үнэлгээ өгсөн нь гэмт хэргээс сэргийлэх ерөнхий хандлага нь **айдастай** байдаг гэсэн судалгааны дүн харуулж байна. Баян-Өлгий, Дорнод, Хэнтий, Говь-Алтай, Орхон, Дундговь, Говьсүмбэр, Архангай, Өмнөговь, Увс, Сүхбаатар, Завхан, Өвөрхангай аймаг, Чингэлтэй дүүргийн иргэд дунджаас доогуур буюу айдас багатай амьдардаг гэж хариулсан бол Төв, Дархан-Уул, Дорноговь, Ховд, Баянхонгор, Хөвсгөл, Сэлэнгэ, Булган аймаг, Сүхбаатар, Баянзүрх, Хан-Уул, Сонгинохайрхан, Баянгол дүүргийн иргэд дунджаас дээгүүр буюу айдас амьдардаг гэж хариулсан байна.

## ЗӨВЛӨМЖ

1. Цагдаагийн байгууллагын зүгээс дунджаас доогуур үнэлгээ авсан бүс, аймаг тус бүр хэрэглэгчийн үнэлгээг нэмэгдүүлэх, дунджаас дээгүүр үнэлгээ авсан бүс, аймаг тус бүр үйл ажиллагаагаа улам сайжруулах шаардлагатай. Судалгааны тайланд дурдагдсан үзүүлэлтүүдээс тус бүр дээр дүн шинжилгээ хийж улсын хэмжээнд хэрэглэгчийн үнэлгээний дундаж үзүүлэлтийг **(4.0)** ба түүнээс түвшинд гаргах чиглэлээр ажиллах;
2. Цагдаагийн байгууллагад өгөх хэрэглэгчийн үнэлгээг нэмэгдүүлэхэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах, оршин суугчдын аюулгүй тайван амьдрах, гэмт хэргээс айх хандлагын түвшинг бууруулах, ялангуяа хөдөө орон нутагт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ хангалтгүй байгааг анхаарч ажиллах;
3. Цагдаагийн байгууллага иргэдээс хүлээн авсан гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг хуулийн дагуу шуурхай шийдвэрлэж, хариу өгөх ажиллагааг хуулийн хүрээнд хурдан шуурхай шийдвэрлэдэг байх, иргэдээс гаргасан гомдол мэдээллийн хариуг цаг тухайд мэдэгдэж, авсан арга хэмжээний талаар танилцуулж байх;
4. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа ил тод, эргэлзээгүй байдалд иргэд хамгийн доогуур үнэлгээ өгсөн байгааг харгалзан, иргэдэд нээлттэй болгох мэдээллийн жагсаалтыг гаргах, иргэд хэрэг хянан шалгах ажиллагаа, алба хаагчтай холбоотой хувийн мэдээллийн талаар хамгийн их мэдээлэл авах хандлагатай байгаагаас шалтгаалан иргэд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг ил тод биш гэж үзэж байна. Тиймээс хуулийн хүрээнд ил болгох боломжтой мэдээллийн талаар оршин сууж буй нутаг дэвсгэрийнхээ иргэдэд мэдээлэл, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулж байх;
5. Цагдаагийн албаны тухай хууль, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн холбогдох заалтуудыг үндэслэн гудамж талбай, нийтийн эзэмшлийн газрыг бүрэн камержуулах, цэцэрлэгт хүрээлэн, биеийн тамирын талбай, хүүхдийн тоглоомын газар зэрэг оршин суугчдын чөлөөт цагаа өнгөрүүлэх газрыг нэмэгдүүлэх талаар орон нутгийн засаг захиргааны байгууллагуудад тодорхой санал гаргаж, хамтран ажиллах;
6. Цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшил, мэдлэг ур чадварыг сайжруулах талаар нэгдсэн сургалт, соёл олон нийтийн арга хэмжээг тогтмол зохион байгуулж байх, ялангуяа хөдөө орон нутгийн алба хаагчдад чиглэгдсэн арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх зэрэг болно.
7. Цагдаагийн байгууллагын хэрэглэгчийн үнэлгээний судалгааны бүрдэл хэсэгт хамтран ажилладаг байгууллагын сэтгэл ханамжийн судалгааг тогтмол оруулах, судалгаанд оролцогчдын тоо, санхүүжилтийг нэмэгдүүлэх, судалгаа явуулах, дүн шинжилгээ хийх аргачлалд шинжлэх ухаанч байдлаар хандаж бодит дүгнэлт гаргахад онцгой анхаарах;
8. Тухайн жилийн үнэлгээг өмнөх жилийн үнэлгээтэй харьцуулах замаар хэрэглэгчийн үнэлгээнд гарч байгаа өөрчлөлтөд дүн шинжилгээ хийж, үр дүнг үндэслэн хариуцлага хүлээлгэх, урамшуулах тогтолцоонд шилжих;

## Иргэдээс авсан нээлттэй асуулгын дүнгийн давталт

Улаанбаатар хот

Баянгол дүүрэг	Эргүүлийн цагдаа, машин цаг хугацааг нэмэгдүүлж, тогтмол эргүүл гаргах	5
	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулах	5
	Дуудлага хүлээн аваад түргэн шуурхай ирдэг болох	4
	Гэр хороололд хяналтыг сайжруулах хэрэгтэй	3
	Иргэдийг хүндэтгэх	3
	Шөнийн цагаар үйл ажиллагаа муу явуулдаг, гэмт хэрэг их гарч байдаг	2
	Иргэддээ шударга хандах	2
	Ард түмнээ гэсэн сэтгэлгээг төлөвшүүлэх	2
	Цагдаагийн пост байршуулах	1
	Цагдаагийн ажилтны хүний нөөцийг нэмэгдүүлэх	1
	Ур чадварыг дээшлүүлэх	1
Сонгинохайрхан дүүрэг	Цагдаа нар иргэдтэй хамтын ажиллагааг сайжруулах	3
	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлуудыг сайн явуулах	3
	Архидан согтуурсан хүмүүст арга хэмжээ авах	2
	Камержуулалт болон гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх	2
	Гэмт хэрэг зөрчил гарч болзошгүй газар камержуулах, эргүүлийн цагдаа нарыг нэмэх	2
	Дуудлага өгөхөд цаг хугацаандаа ирэх	1
	Хаяг байршлаа сайн мэддэг, хүнийг ялгаварлан харьцахгүй байвал зохино	1
Сүхбаатар дүүрэг	Эргүүлийн ажиллагааг сайжруулах	2
	Дүүрэг дүүргийн цагдаа нар хороо нь дээрээ жижүүрт суудаг байвал маш сайн байна	1
	Гэрэлтүүлэг бүрэн тавих шаардлагатай байна	1
	Асуудалд шуурхай хандах	1
	Ард иргэдтэй хамтарсан үйл ажиллагаа зохион байгуулах	1
	Камерын хяналтыг сайжруулах	1
Чингэлтэй дүүрэг	Эргүүл шалгалт, алба хаагчдын тоо, техник хэрэгслийн чадамжийг дээшлүүлэх	1
	Харанхуй орчинг гэрэлтүүлэх камержуулах	4
	Оройн цагаар эргүүлийг сайн гаргах	2
	Хулгайд алдсан юм илрүүлэлт сайн байх хэрэгтэй байна	2
	Цагдаагийн хүч хүрэлцэхгүй үед иргэдийн дэмжлэгийг авч байх	1
	Шаардагдах багаж хэрэгсэл машин техникийг нэмэх хэрэгтэй	1
Хан-Уул дүүрэг	Хулгайг сайн илрүүлэх	1
	Иргэн болгоны хүсэлт гомдлыг түргэн шуурхай шийдвэрлэж байх	2
	Цагдаа нар харилцааны соёлтой байх	2
	Камер, гэрэлтүүлгээр бүрэн хангах	2
	Сургалт зохион байгуулах, гадаадад мэргэжил дээшлүүлэх	2
	Эргүүл хийж байгаа цагдаагийн ажилтан гудамж нэг бүрээр шалгаж байх	2
	Ажилгүй тэнэмэл архичдыг байхгүй болгох	1
	Том тэргийг явуулахыг хориглох	1
	Агаарын бохирдолтой тэмцэх	1
	Цагдаагийн байгууллагын ур чадвар сайжирсаар байгаа	1
	Цагдаагийн ажилчид гайгүй боломжийн ажилдаг	1
Баянзүрх дүүрэг	Байр, машины зогсоол, гэр хорооллыг бүрэн камержуулах	4
	Иргэдийн гомдол саналыг хурдан шийдэх	2
	Цагдаа нар эрх үүргийнхээ дагуу зөв боловсон харьцах	2
	Гэмт хэргийн талаарх мэдээллийг хохирогчдод мэдээлж байх	1
	Цагдаагийн байгууллагын салбар нэгжийн байршлыг дэлгэрэнгүй танилцуулж байх	1
	Ард иргэдтэй илүү ойрхон байж илүү тод ажиллах	1
	Үүргээ сайн биелүүлдэг	1
	Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа	1



ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ  
ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ-2017

**Хоёр. ХАМТРАН АЖИЛЛАДАГ БАЙГУУЛЛАГЫН  
СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ  
ХЭСЭГЧИЛСЭН ТАЙЛАН**

*(Нийслэлийн 6 дүүргийн хэмжээнд)*

## 1. УДИРТГАЛ

### *1.1 Судалгааны үндэслэл, шаардлага*

Монгол Улсын Засгийн Газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын шалгуур үзүүлэлт”, Хууль зүйн сайдын 2014 оны А/01 дүгээр тушаалаар батлагдсан “Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт-шинжилгээ үнэлгээний аргачлал”-ийг үндэслэн Цагдаагийн Ерөнхий Газар хэрэглэгчийн үнэлгээний тайланг жил бүр гаргах үүрэг хүлээсэн. 2012-2016 оны хооронд Цагдаагийн ерөнхий газрын захиалгаар хөндлөнгийн судалгааны байгууллагууд “Цагдаагийн байгууллагын хэрэглэгчийн үнэлгээний тайлан”-г 5 удаа гаргажээ. Судалгааны дүнгээс үзвэл цагдааг үнэлэх хэрэглэгчийн үнэлгээ жил бүр нэмэгдэж байгаа талаар дурдсан байна.

Хэдийгээр цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хэрэглэгчийн үнэлгээ, алба хаагчдын албандаа хандах сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа ч олон нийт, ялангуяа гэмт хэрэг, зөрчлийн улмаас эрх ашиг нь хөндөгдсөн иргэд цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд төдийлөн сэтгэл ханамжгүй байх хандлага ажиглагдсаар байна.

Иймээс гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг сайжруулах, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар олон нийтийн итгэлийг хүлээх ажлыг хэрэгжүүлэхэд хэрэглэгчийн үнэлгээний судалгаа онцгой ач холбогдолтой тул хамтран ажилладаг байгууллагын төлөөллийн үнэлгээг харгалзах зайлшгүй шаардлагатай болсон.

### *1.2 Судалгааны ажлын зорилго, зорилт*

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг үнэлэх хэрэглэгчийн үнэлгээний аргачлал боловсруулах, боловсруулсан аргачлалын дагуу судалгаа явуулж, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд үнэлгээ өгөх, цаашид авах арга хэмжээний зөвлөмж боловсруулахад оршино. Судалгааны ажлын хүрээнд цагдаагийн байгууллагатай хамтран ажилладаг зарим байгууллагын төлөөлөөс цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгаа авч, дүгнэлт хийсэн болно.

### *1.3 Судалгааны ажлын онцлог*

Цагдаагийн байгууллагын хэрэглэгчийн үнэлгээг тодорхойлох зорилгоор өмнө нь явуулсан судалгаа нь ихэнх тохиолдолд Улаанбаатар хотын иргэдийн дунд явуулдаг байсан бол энэ удаа нийслэлийн 6 дүүрэг, 21 аймгийн иргэдийн төлөөллийг хамруулснаас гадна хамтран ажилладаг байгууллагын санал бодлыг тусгаж, судалгааны үр дүнг Улаанбаатар хотын дүүрэг, тус бүрээр нь гаргаж, дундаж оноогоор нь эрэмбэлэн харуулсан онцлогтой.

### *1.4 Судалгааны арга зүй, түүвэрлэлт*

Судалгааны ажлын зорилтод нийцүүлэн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд өгөх хамтран ажилладаг байгууллагын үнэлгээг тодорхойлох асуулгыг 5 бүлэг 11 асуулттайгаар боловсруулж, үзүүлэлт бүрийг Ликертийн хэмжүүрээр 5 хүртэл оноогоор үнэлж, хэрэглэгчийн үнэлгээний түвшинг бүлэг тус бүрээр болон нэгдсэн дүнгээр тодорхойлов.

### Судалгааны түүвэрлэлт

Хамтран ажилладаг байгууллагын төлөөллийг сонгохдоо цагдаагийн байгууллагатай хамтран ажилладаг хамгийн гол гэсэн 10 чиглэлийг харгалзсан ба судалгаанд нийт 291 оролцогч өөрсдийн байгууллагыг төлөөлөн оролцжээ. Хамтран ажилладаг байгууллагаас төлөөлөөс түүвэрлэлтийг хийхдээ тухайн байгууллагын өмнөөс асуултад оновчтой хариулт өгөх туршлагатай хүнийг байгууллага тус бүр өөрсдөө санал болгох замаар түүвэрлэлтийг бүрдүүлсэн бөгөөд таны хариулт байгууллагыг төлөөлж байгаа гэдгийг тайлбарлан ойлгуулсан.

### Мэдээлэл цуглуулалт

Судалгааг нээлттэй нийгэм форум хүрээлэнгийн Улаанбаатар хот орон нутаг дахь судалгааны салбар байгууллагуудаар дамжуулан гүйцэтгэсэн. Судалгаа явуулах судлаачдад судалгаа явуулах арга

зүй, аюулгүй байдлаа хангах сургалт, урьдчилсан тестийг 2017 оны 08 дугаар сарын 24-ний өдөр Шүүхийн ерөнхий зөвлөлийн сургалтын төвд явуулж, орон нутаг дахь судалгааг 2017 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 06-ны хооронд, Улаанбаатар хот дахь судалгааг 2017 оны 12 дугаар сарын 03-ны өдрөөс 12 дугаар сарын 20-ны өдрийн хооронд нүүр тулсан ярилцлага хийх замаар мэдээллийг цуглуулсан.

**Мэдээлэл боловсруулалт**

Тайланг хэрэглэгчдэд ойлгомжтой, хүртээмжтэй болгох үүднээс Монгол Улсын Үндэсний статистикийн хорооноос эрхлэн гаргадаг “Монгол улсын статистикийн эмхтгэл”-ийн аргачлалд тулгуурлан Улаанбаатар хот, 4 бүс гэсэн ангиллаар судалгааны үр дүнг харуулж, харьцуулалт хийв. Үзүүлэлт бүрийн жигнэсэн дундаж, дээд, доод утга, медиан, стандарт хазайлт зэрэг статистик үзүүлэлтийг тооцохын зэрэгцээ, үзүүлэлтүүд хоорондын хамаарлыг статистик шинжүүрийн тусламжтайгаар тооцон тодорхойлж, зохих сорил шинжүүрээр шалгаж магадлав.

**1.5 Судалгааны хамрах хүрээ, хязгаарлалт**

Улаанбаатар хотын хэрэглэгчийн үнэлгээг тодорхойлох судалгаа хугацаанаас хожимдож эхэлсэнтэй холбоотойгоор зөвхөн төвийн 6 дүүргийн төлөөллийг хамруулан судалгааг явуулсан. Улаанбаатар хотын 6 дүүрэгт нийт 14 цагдаагийн хэлтэс үйл ажиллагаа явуулж байгаа ба тайланд дурдагдсан нийслэлийн дүүргүүдийн дүн нь хэлтэс тус бүрээрээ гараагүй болно.

**2. СУДАЛГААНД ХАМРАГДСАН БАЙГУУЛЛАГУУДЫН ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАДАГ ЧИГЛЭЛ**


**2.6 Улаанбаатар хотын бусад байгууллагын цагдаагийн байгууллагатай хамтран ажилладаг чиглэл**  
**Улаанбаатар хотын бусад байгууллагын цагдаагийн байгууллагатай хамтран ажилладаг чиглэл**

д/д	Хамтран ажилладаг чиглэл	Нийт	Баянгол дүүрэг	Сонгинохайрхан дүүрэг	Сүхбаатар дүүрэг	Чингэлтэй дүүрэг	Хан-Уул дүүрэг	Баянзүрх дүүрэг
1	Гэмт хэрэг илрүүлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр	35	9	6	6	3	4	9
2	Хэрэг бүртгэл, мөрдөн байцаах ажиллагааг хамтран хэрэгжүүлэх, мэргэжлийн удирдлагаар хангах чиглэл	16	2	2	2	4	4	3
3	Нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн эргүүл зохион байгуулах чиглэлээр	22	6	2	4	1	4	6
4	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр	12	3	2	-	2	2	4
5	Боловсролын үйлчилгээ үзүүлэх чиглэлээр	3	-	-	1	1	1	-
6	Аж ахуй, хувцас, санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр	5	-	-	1	-	1	3
7	Хүний эрхийг хамгаалах, хангуулах чиглэлээр	22	3	3	4	4	5	4
8	Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр (Сургууль)	21	6	2	4	2	3	5
9	Хувийн хэвшил	5	2	-	-	1	1	1
10	Байгаль хамгаалах чиглэлээр	2	-	-	-	-	1	1
<b>Давхардсан тоогоор нийт дүн</b>		<b>143</b>	<b>31</b>	<b>17</b>	<b>22</b>	<b>18</b>	<b>26</b>	<b>36</b>
<b>Судалгаанд хамрагдсан байгууллагын тоо</b>		<b>58</b>	<b>11</b>	<b>7</b>	<b>10</b>	<b>10</b>	<b>10</b>	<b>10</b>

Дээрх хүснэгтээс харахад Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн 58 байгууллага судалгаанд хамрагдсан бөгөөд цагдаагийн байгууллагатай хамтран ажилладаг тэргүүлэх 3 чиглэл нь нэгдүгээрт:

“Гэмт хэрэг илрүүлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр” хамгийн олон буюу 35 байгууллага, нийт байгууллагын 60.3%, хоёрдугаарт “Хүний эрхийг хамгаалах, хангуулах чиглэлээр”, “Нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн эргүүл зохион байгуулах чиглэлээр” тус бүр 22 байгууллага буюу 37.9%, гуравдугаарт “Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр (Сургууль)” 21 байгууллага буюу 36.2%, харин хамгийн цөөн 2 байгууллага буюу 3.4% нь “Байгаль хамгаалах чиглэлээр”, 3 байгууллага буюу 5.2% нь “Боловсролын үйлчилгээ үзүүлэх чиглэлээр” тус тус хамтарч ажилладаг байна.

Улаанбаатар хотын бусад байгууллагын цагдаагийн байгууллагатай хамтран ажилладаг чиглэл



### 3. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУУЛЬ ЁСНЫ БАЙДАЛ

Монгол Улсын Үндсэн Хуульд зааснаар хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн. Тиймээс Цагдаагийн алба хаагч үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль, тогтоомжийг мөрдлөг болгон ажиллах үүрэгтэй. Үүнийг цагдаагийн байгууллагатай хамтран ажилладаг нийт улсын хэмжээгээр 291 байгууллагаар үнэлүүлсэн бөгөөд үнэлгээний үр дүнг улсын хэмжээ, бүс, аймаг, дүүргийн хэмжээгээр тус бүр боловсруулав.

#### 3.6 Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны хууль ёсны байдал

**Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын хууль ёсны байдлын талаарх бусад байгууллагын сэтгэл ханамжийн үнэлгээ /дүүргээр/**

Дүүргээр	Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны хууль ёсны байдал					
	Цагдаагийн байгууллага нь танай байгууллагатай хамтран ажиллаж та бүхний хүссэн ажиллагааг шуурхай, хуулийн дагуу шийдвэрлэж, хугацаанд нь хариу өгдөг	Цагдаагийн алба хаагчид үйл ажиллагаандаа хуулийг баримтлан шударга ёсыг эрхэмлэн ажилладаг	Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа ил тод бөгөөд эргэлзээгүй байдаг	Цагдаагийн алба хаагч үйл ажиллагаа явуулахдаа хүний эрх, эрх чөлөөг хангаж ажилладаг	Дундаж	Стандарт хазайлт
<b>Баянгол</b>	<b>3.91</b>	<b>3.73</b>	<b>3.45</b>	<b>3.73</b>	<b>3.70</b>	1.1
Баянзүрх	3.60	3.50	3.50	3.60	3.55	0.9
Сонгинохайрхан	3.57	3.57	3.14	3.43	3.43	1.3
Сүхбаатар	3.40	3.30	2.90	3.10	3.18	0.85
<b>Хан-Уул</b>	<b>3.91</b>	<b>3.91</b>	<b>3.73</b>	<b>3.82</b>	<b>3.84</b>	0.9
Чингэлтэй	3.45	3.45	3.18	3.36	3.36	0.9
<b>Ерөнхий дундаж</b>	<b>3.64</b>	<b>3.58</b>	<b>3.32</b>	<b>3.51</b>	<b>3.51</b>	<b>0.99</b>

Тайлбар: Огт санал нийлэхгүй – 1, санал нийлэхгүй – 2, Дунд зэрэг – 3, Санал нийлнэ – 4, Бүрэн санал нийлнэ – 5

Дээрх хүснэгтээс харахад Улаанбаатар хотын 6 дүүргийн хувьд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны хууль ёсны байдалд хамтран ажилладаг 58 байгууллагын зүгээс сэтгэл ханамжийг ерөнхийд нь **3.51** буюу сэтгэл ханамжтай гэж үнэлсэн, стандарт хазайлт 0.99 гэдэг нь дундаж үзүүлэлт төлөөлөх чадвартай, алдаа бага байгааг илэрхийлнэ. Хотын хэмжээнд дунджаас дээгүүр үнэлгээг Баянгол, Баянзүрх, Хан-Уул дүүргүүд өгсөн бол Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй дүүргүүд дунджаас доогуур үнэлгээ өгсөн байна. Баянгол, Хан-Уул зэрэг дүүргүүд бүх үзүүлэлтээр дунджаас дээгүүр үнэлгээ өгч Улаанбаатар хотод тэргүүлж байна.

**“Цагдаагийн байгууллага нь танай байгууллагатай хамтран ажиллаж та бүхний хүссэн ажиллагааг шуурхай, хуулийн дагуу шийдвэрлэж, хугацаанд нь хариу өгдөг”** гэсэн асуултанд бусад байгууллагын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ **3.64** бөгөөд Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул зэрэг дүүрэг өгсөн бол Сүхбаатар, Чингэлтэй дүүргүүд дунджаас доогуур үнэлгээ өгсөн байна.

**“Цагдаагийн алба хаагчид үйл ажиллагаандаа хуулийг баримтлан шударга ёсыг эрхэмлэн ажилладаг”** гэсэн асуултанд бусад байгууллагын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ **3.58** бөгөөд Баянгол, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргүүд дунджаас дээгүүр, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй зэрэг дүүргүүд дунджаас доогуур үнэлгээ өгсөн байна.

**“Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа ил тод бөгөөд эргэлзээгүй байдаг”** гэсэн асуултанд бусад байгууллагын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ **3.32** бөгөөд дунджаас дээгүүр үнэлгээг Баянгол, Баянзүрх, Хан-Уул зэрэг дүүргүүд өгсөн бол Сонгинохайрхан, Сүхбаатар Чингэлтэй дүүргийн бусад байгууллагууд дунджаас доогуур үнэлжээ.

**“Цагдаагийн алба хаагч үйл ажиллагаа явуулахдаа хүний эрх, эрх чөлөөг хангаж ажилладаг”** гэсэн асуултанд бусад байгууллагын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ **3.51** бөгөөд дунджаас дээгүүр үнэлгээг мөн Баянгол, Баянзүрх, Хан-Уул зэрэг дүүргүүд өгсөн бол Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн бусад байгууллагууд дунджаас доогуур үнэлжээ. Хэдийгээр дундажтай харьцуулахад доогуур боловч энэ нь сэтгэл ханамж дунд зэрэг буюу тодорхой хэмжээнд сэтгэл ханамж байна гэсэн үг юм.

#### **4. ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧДЫН ХАРИЛЦААНЫ СОЁЛ, ЁС ЗҮЙН ТӨЛӨВШИЛ**

Цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийг цагдаагийн байгууллагатай хамтран ажилладаг нийт улсын хэмжээгээр 291 байгууллагаар үнэлүүлсэн бөгөөд үнэлгээний үр дүнг

улсын дүнгээр, бүс, аймаг, дүүргийн хэмжээгээр тус бүр боловсруулав. Улаанбаатар хотын 6 дүүргийн 58 байгууллага судалгаанд хамрагдав.

#### 4.1 Цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшил, улсын дүнгээр

Цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшилд хамтран ажиллагч байгууллагын зүгээс өгсөн үнэлгээний үр дүнг Монгол улсын 4 бүсийн 21 аймгийн 233 байгууллага, Улаанбаатар хотын 6 дүүргийн 58 байгууллага, нийт 291 байгууллага буюу улсын дүнгээр сэтгэл ханамжийн үнэлгээг нэгтгэж харуулав.

#### Цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ /улсын дүнгээр/

Асуултууд	Дундаж	Стандарт хазайлт	Огт санал нийлэхгүй		Санал нийлэхгүй		Дунд зэрэг		Санал нийлнэ		Бүрэн санал нийлнэ	
			Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Манай орон нутгийн цагдаагийн байгууллагын алба хаагчид харилцааны өндөр соёлтой, стандарт дүрмээ баримтлан ажилладаг	3.19	0.91	16	5.5	32	11.0	142	48.8	83	28.5	18	6.2
Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах, алба хаагчаас мэдээлэл авах, харилцан ойлголцоход хялбархан байдаг	3.5	0.88	6	2.1	26	8.9	108	37.1	119	40.9	32	11.0
Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах шаардлагатай үед тэд бэлэн байж, хүлээсэн үүргээ хангалттай биелүүлдэг	3.65	0.83	3	1.0	18	6.2	96	33.0	135	46.4	39	13.4
Цагдаагийн байгууллагын алба хаагчийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар хангалттай гэж үздэг	3.45	0.81	3	1.0	27	9.3	119	40.9	120	41.2	22	7.6
<b>Ерөнхий дундаж</b>	<b>3.45</b>	<b>0.86</b>	<b>7</b>	<b>2.4</b>	<b>26</b>	<b>8.9</b>	<b>116</b>	<b>40.0</b>	<b>114</b>	<b>39.3</b>	<b>28</b>	<b>9.6</b>

Тайлбар: Огт санал нийлэхгүй – 1, санал нийлэхгүй – 2, Дунд зэрэг – 3, Санал нийлнэ – 4, Бүрэн санал нийлнэ – 5  
Эх үүсвэр: Судлаачийн SPSS.21 –р тооцсон үр дүн

Дээрх хүснэгтээс харахад Монгол улсын хэмжээнд цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн талаарх сэтгэл ханамжийн ерөнхий дундаж үнэлгээ **3.45** буюу сэтгэл ханамжтай гэсэн үнэлгээг өгсөн бөгөөд стандарт хазайлт **0.86** гэдэг нь дундаж үзүүлэлтийн төлөөлөх чадвар сайн байгааг илэрхийлэх бөгөөд алдаа бага байгааг харуулна.

*Манай орон нутгийн цагдаагийн байгууллагын алба хаагчид харилцааны өндөр соёлтой, стандарт дүрмээ баримтлан ажилладаг* гэсэн асуултанд хамгийн бага үнэлгээ 3.19 буюу дунд зэрэг санал нийлнэ гэж хариулсан бол

*Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах шаардлагатай үед тэд бэлэн байж, хүлээсэн үүргээ хангалттай биелүүлдэг* гэсэн асуултанд хамгийн өндөр дундаж үнэлгээ 3.65 буюу санал нийлнэ гэж хариулт өгсөн байна.


Үүнийг хариулт бүрээр харахад цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны хууль ёсны байдыг үнэлэх “Манай орон нутгийн цагдаагийн байгууллагын алба хаагчид харилцааны өндөр соёлтой, стандарт дүрмээ баримтлан ажилладаг” гэсэн асуултанд байгууллагын санал нийлэлтийн дундаж үнэлгээ **3.19** буюу санал дунд зэрэг нийлнэ гэж хариулсан бөгөөд нийт судалгаанд оролцогчдын 5.5% буюу 16 байгууллага огт санал нийлэхгүй, 11% буюу 32 байгууллага санал нийлэхгүй, 48.8% буюу 142 байгууллага дунд зэргийн санал нийлнэ, 28.5% буюу 83 байгууллага санал нийлнэ, 6.2% буюу 18 байгууллага бүрэн санал нийлнэ гэж хариулт өгсөн байна.

“Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах, алба хаагчаас мэдээлэл авах, харилцан ойлголцоход хялбархан байдаг” гэсэн асуултанд байгууллагын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ **3.5**

буюу санал нийлнэ гэж хариулсан бөгөөд нийт судалгаанд оролцогчдын 2.1% буюу 6 байгууллага огт санал нийлэхгүй, 8.9% буюу 26 байгууллага санал нийлэхгүй, 37.1% буюу 108 байгууллага дунд зэргийн санал нийлнэ, 40.9% буюу 119 байгууллага санал нийлнэ, 11% буюу 32 байгууллага бүрэн санал нийлнэ гэж хариулт өгсөн байна


**“Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах шаардлагатай үед тэд бэлэн байж, хүлээсэн үүргээ хангалттай биелүүлдэг”** гэсэн асуултанд байгууллагын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ **3.65** буюу санал нийлнэ гэж хариулсан бөгөөд нийт судалгаанд оролцогчдын 1% буюу 3 байгууллага огт санал нийлэхгүй, 6.2% буюу 18 байгууллага санал нийлэхгүй, 33% буюу 96 байгууллага дунд зэргийн санал нийлнэ, 46.4% буюу 135 байгууллага санал нийлнэ, 13.4% буюу 39 байгууллага бүрэн санал нийлнэ гэж хариулт өгсөн байна.

Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах шаардлагатай үед тэд бэлэн байж, хүлээсэн үүргээ хангалттай биелүүлдэг талаарх үнэлгээ



**“Цагдаагийн байгууллагын алба хаагчийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар хангалттай гэж үздэг”** гэсэн асуултанд байгууллагын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ **3.45** буюу санал нийлнэ гэж хариулсан бөгөөд нийт судалгаанд оролцогчдын 1% буюу 3 байгууллага огт санал нийлэхгүй, 9.3% буюу 27 байгууллага санал нийлэхгүй, 40.9% буюу 119 байгууллага дунд зэргийн санал нийлнэ, 41.2% буюу 120 байгууллага санал нийлнэ, 7.6% буюу 22 байгууллага бүрэн санал нийлнэ гэж хариулт өгсөн байна.

Цагдаагийн байгууллагын алба хаагчийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар хангалттай гэж үздэг талаарх үнэлгээ



#### 4.6 Улаанбаатар хотын цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн байдал

Улаанбаатар хотын цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн талаарх үнэлгээ /дүүргээр/

Дүүргээр	Цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшил					
	Манай орон нутгийн цагдаагийн байгууллагын алба хаагчид харилцааны өндөр соёлтой, стандарт дүрмээ баримтлан ажилладаг	Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах, алба хаагчаас мэдээлэл авах, харилцан ойлголцоход хялбархан байдаг	Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах шаардлагатай үед тэд бэлэн байж, хүлээсэн үүргээ хангалттай биелүүлдэг	Цагдаагийн байгууллагын алба хаагчийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар хангалттай гэж үздэг	Дундаж	Стандарт хазайлт
Баянгол	3.55	3.36	3.91	3.55	3.59	0.98
Баянзүрх	3.20	3.70	4.00	3.70	3.65	1.02
Сонгинохайрхан	3.29	3.86	4.14	3.57	3.72	0.78
Сүхбаатар	3.40	3.50	3.60	3.50	3.50	0.76
Хан-Уул	4.10	3.80	3.70	4.20	3.95	0.65
Чингэлтэй	3.00	3.20	3.50	3.40	3.28	0.71
<b>Ерөнхий дундаж</b>	<b>3.42</b>	<b>3.57</b>	<b>3.81</b>	<b>3.65</b>	<b>3.61</b>	<b>0.82</b>

Тайлбар: Огт санал нийлэхгүй – 1, санал нийлэхгүй – 2, Дунд зэрэг – 3, Санал нийлнэ – 4, Бүрэн санал нийлнэ – 5

Дээрх хүснэгтээс харахад Улаанбаатар хотын хувьд цагдаагийн байгууллагын алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшилд хамтран ажилладаг бусад байгууллагын зүгээс сэтгэл ханамжийг ерөнхийд нь **3.61** буюу сэтгэл ханамжтай гэж үнэлсэн бөгөөд дунджаас дээгүүр үнэлгээг Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргүүд өгсөн бол, Баянгол, Сүхбаатар, Чингэлтэй дүүргүүд дунджаас доогуур үнэлгээ өгсөн байна.

“Манай орон нутгийн цагдаагийн байгууллагын алба хаагчид харилцааны өндөр соёлтой, стандарт дүрмээ баримтлан ажилладаг” гэсэн асуултанд хамтран ажилладаг бусад байгууллагын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ **3.42** бөгөөд Баянгол, Хан-Уул зэрэг дүүрэг дундаж үнэлгээнээс дээгүүр, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй зэрэг дүүрэг дунджаас доогуур үнэлжээ.


“Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах, алба хаагчаас мэдээлэл авах, харилцан ойлголцоход хялбархан байдаг” гэсэн асуултанд бусад байгууллагын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ **3.57** бөгөөд дунджаас дээгүүр үнэлгээг Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргүүд дунджаас дээгүүр, Баянгол, Сүхбаатар, Чингэлтэй зэрэг дүүрэг дунджаас доогуур үнэлжээ.

“Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах шаардлагатай үед тэд бэлэн байж, хүлээсэн үүргээ хангалттай биелүүлдэг” гэсэн асуултанд бусад байгууллагын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ **3.81** бөгөөд дунджаас дээгүүр үнэлгээг Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүд өгсөн бол, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй зэрэг дүүрэг дунджаас доогуур үнэлжээ.

“Цагдаагийн байгууллагын алба хаагчийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар хангалттай гэж үздэг” гэсэн асуултанд бусад байгууллагын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ **3.65** бөгөөд дунджаас дээгүүр үнэлгээг Баянзүрх, Хан-Уул зэрэг дүүрэг дунджаас дээгүүр, Баянгол, Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй зэрэг дүүрэг дунджаас доогуур үнэлжээ. Хэдийгээр дундажтай харьцуулахад доогуур боловч энэ нь сэтгэл ханамж муу байна гэсэн үг биш юм. Үүнийг дараах зургаар илэрхийлье.

Улаанбаатар хотын цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн байдлын талаарх үнэлгээ /дүүргээр/





## 5. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ СЭТГЭЛ ХАНАМЖИЙН БАЙДАЛ

### 5.6 Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь сэтгэл ханамж

Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь сэтгэл ханамжийн үнэлгээ /дүүргээр/

Дүүргээр	Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь сэтгэл ханамж			
	Бид цагдаагийн байгууллагатай хамтран ажилласан тохиолдолд сэтгэл ханамж өндөр байдаг	Манай орон нутгийн аюулгүй байдлыг цагдаагийн байгууллага хангаж чадна гэдэгт бид итгэдэг	Дундаж	Стандарт хазайлт
Баянгол	<b>3.91</b>	3.82	<b>3.87</b>	1.24
Баянзүрх	3.60	3.90	3.75	0.92
Сонгинохайрхан	3.71	<b>4.29</b>	<b>4.00</b>	0.85
Сүхбаатар	3.70	3.50	3.60	0.82
<b>Хан-Уул</b>	<b>4.00</b>	<b>4.30</b>	<b>4.15</b>	0.67
Чингэлтэй	3.70	3.70	3.70	0.48
<b>Ерөнхий дундаж</b>	<b>3.77</b>	<b>3.92</b>	<b>3.84</b>	<b>0.83</b>


Тайлбар: Огт санал нийлэхгүй – 1, санал нийлэхгүй – 2, Дунд зэрэг – 3, Санал нийлнэ – 4, Бүрэн санал нийлнэ – 5

Дээрх хүснэгтээс харахад Улаанбаатар хотын хувьд цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь хамтран ажилладаг байгууллагуудын сэтгэл ханамжийн ерөнхий дундаж үнэлгээ **3.84** буюу **сэтгэл ханамжтай** гэсэн үнэлгээг өгсөн бөгөөд дунджаас дээгүүр үнэлгээг Баянгол, Сонгинохайрхан, Хан-Уул зэрэг дүүрэг өгсөн бол, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргүүд дунджаас доогуур үнэлгээ өгсөн байна. Хан-Уул дүүрэг 2 үзүүлэлтээрээ дунджаас дээгүүр үнэлгээ авч Улаанбаатар хотдоо тэргүүлж байна.

“Бид цагдаагийн байгууллагатай хамтран ажилласан тохиолдолд сэтгэл ханамж өндөр байдаг” гэсэн асуултанд бусад байгууллагын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ **3.77** бөгөөд дунджаас дээгүүр үнэлгээг Баянгол, Хан-Уул дүүргүүд өгсөн бол Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргүүд дунджаас доогуур үнэлгээ өгсөн байна.

“Манай орон нутгийн аюулгүй байдлыг цагдаагийн байгууллага хангаж чадна гэдэгт бид итгэдэг” гэсэн асуултанд бусад байгууллагын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ **3.92** бөгөөд дунджаас дээгүүр үнэлгээг Сонгинохайрхан, Хан-Уул зэрэг дүүрэг өгсөн бол Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргүүд дунджаас доогуур үнэлгээ өгсөн байна. Хэдийгээр дундажтай харьцуулахад доогуур боловч энэ нь сэтгэл ханамж муу байна гэсэн үг биш юм. Үүнийг дараах зургаар илэрхийлье.

**Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны сэтгэл ханамжийн үнэлгээ /дүүргээр/**



**6. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАДАГ БАЙГУУЛЛАГУУДЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ**

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгаанд цагдаагийн байгууллагатай 10 чиглэлээр хамтран ажилладаг Монгол улсын 4 бүсийн 21 аймгийн 233 байгууллага, Улаанбаатар хотын 6 дүүргийн 58 байгууллага нийт 291 байгууллага хамрагдсан. Асуулгыг 5 бүлгийн 11 асуултаар авсан бөгөөд сэтгэл ханамжийг илэрхийлэх 10 асуулт бүхий 3 бүлгийн сэтгэл ханамжийн ерөнхий дундаж үнэлгээг эрэмбэлж байр эзлүүлэв.


**Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн  
ерөнхий үнэлгээ /эрэмбээр/**

№	Улсын хэмжээнд	Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны хууль ёсны байдал	Цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшил	Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь сэтгэл ханамж	Нийт үнэлгээний дундаж	Байр
1	Хан-Уул дүүрэг	3.84	3.95	4.15	3.98	I
2	Орхон	3.86	3.68	4.09	3.88	II
3	Төв	3.60	3.63	4.13	3.78	III
4	Хэнтий	3.60	3.75	4.00	3.78	III
5	Дорноговь	3.63	3.65	3.95	3.74	IV
6	Баянгол дүүрэг	3.70	3.59	3.87	3.72	V
7	Сонгинохайрхан дүүрэг	3.43	3.72	4.00	3.71	VI
8	Говьсүмбэр	3.73	3.58	3.80	3.70	V
9	Ховд	3.64	3.55	3.91	3.70	V
10	Сэлэнгэ	3.53	3.38	4.05	3.65	VI
11	Баянзүрх дүүрэг	3.55	3.65	3.75	3.65	VI
12	Өмнөговь	3.45	3.45	3.95	3.62	VII
13	Говь-Алтай	3.63	3.40	3.70	3.58	VIII
14	Завхан	3.55	3.35	3.70	3.53	IX
15	Дорнод	3.48	3.48	3.65	3.53	IX
16	Хөвсгөл	3.45	3.39	3.69	3.51	X
17	Дархан-Уул	3.36	3.41	3.72	3.50	XI
18	Баян-Өлгий	3.48	3.40	3.60	3.49	XII
19	Архангай	3.45	3.24	3.70	3.46	XIII
20	Чингэлтэй дүүрэг	3.36	3.28	3.70	3.45	XIV
21	Баянхонгор	3.40	3.23	3.70	3.44	XV
22	Увс	3.40	3.25	3.65	3.43	XVI
23	Сүхбаатар дүүрэг	3.18	3.50	3.60	3.43	XVI
24	Дундговь	3.28	3.25	3.60	3.38	XVII
25	Өвөрхангай	3.15	3.23	3.65	3.34	XVIII
26	Булган	3.23	3.28	3.50	3.33	XIX
27	Сүхбаатар	3.08	2.83	3.00	2.97	XX
	<b>Улсын дундаж</b>	<b>3.48</b>	<b>3.45</b>	<b>3.77</b>	<b>3.57</b>	

Эх үүсвэр: Судлаачийн SPSS.21 –р тооцсон үр дүн

Дээрх хүснэгтээс харахад улсын дүнгээр нийт 21 аймаг, 6 дүүргийн цагдаагийн байгууллагатай хамтран ажилладаг байгууллагуудын сэтгэл ханамжийн ерөнхий дундаж үнэлгээ 10 асуулт бүхий 3 бүлгийн дүнгээр **3.57** буюу **сэтгэл ханамжтай** гэж үнэлсэн. Байр эзлүүлж үзэхэд *нэгдүгээр байранд* Хан-Уул дүүрэг, *хоёрдугаар байранд* Орхон аймаг, *гуравдугаар байранд* Төв болон Хэнтий аймаг тус тус орсон байна.

Дундаж үзүүлэлтээс дээгүүр үнэлгээтэйд Хан-Уул дүүрэг, Орхон, Төв, Хэнтий, Дорноговь, Баянгол дүүрэг, Сонгинохайрхан дүүрэг, Говьсүмбэр, Ховд, Сэлэнгэ, Баянзүрх дүүрэг, Өмнөговь, Говь-Алтай зэрэг аймгууд орсон бол дунджаас доогуур үнэлгээтэйд Завхан, Дорнод, Хөвсгөл, Дархан-Уул, Баян-Өлгий, Архангай, Чингэлтэй дүүрэг, Баянхонгор, Увс, Сүхбаатар дүүрэг, Дундговь, Өвөрхангай, Булган, Сүхбаатар зэрэг аймгууд орсон байна. Үүнийг дараах зургаар илэрхийлье.



Зураг 1. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн ерөнхий үнэлгээ, эрэмбээр

## ДҮГНЭЛТ

1) Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг 5 бүлгийн 11 асуултаар үнэлж, хамтран ажилладаг байгууллагын төлөөллөөс өгсөн үнэлгээг тооцож үзэхэд нийт 5 оноо авахаас **(3.57)** буюу **сэтгэл ханамжтай** гэж үнэлсэн. Нийт 3 бүлгийн 10 асуултын үнэлгээгээр байр эзлүүлсэн бөгөөд **нэгдүгээр байранд** Хан-Уул дүүрэг 3.98, **хоёрдугаар байранд** Орхон аймаг 3.88, **гуравдугаар байранд** Төв болон Хэнтий аймаг 3.78 үнэлгээтэйгээр тус тус орсон байна. Хэдийгээр дунджаас доогуур үнэлгээтэй хэд хэдэн аймаг, дүүрэг гарсан боловч сэтгэл ханамж дунджаас сайн гэсэн үнэлгээнд хамаарч байгаа нь иргэдээс авсан санал асуулгын дүнтэй харьцуулахад харьцангуй дээгүүр үнэлгээ өгсөн байна. (Хүснэгт 28)

2) Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны хууль ёсны байдалд хамтран ажиллагч байгууллагууд нийт 5 оноо өгөхөөс үр дүн **(3.47)** буюу **сэтгэл ханамжтай** гэж үнэлсэн байна. “Цагдаагийн байгууллага нь танай байгууллагатай хамтран ажиллаж та бүхний хүссэн ажиллагааг шуурхай, хуулийн дагуу шийдвэрлэж, хугацаанд нь хариу өгдөг” гэсэн асуултад сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ хамгийн өндөр буюу **(3.65)** байсан бол “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа ил тод бөгөөд эргэлзээгүй байдаг” гэсэн асуултад сэтгэл ханамжийн үнэлгээ хамгийн бага буюу **(3.32)** гэсэн үзүүлэлттэй гарсан байна. Дээрх үзүүлэлт тийм муу үр дүн биш бөгөөд бусад үзүүлэлттэй харьцуулахад иргэд, хамтран ажилладаг байгууллагын зүгээс цагдаагийн байгууллагыг ил тод биш гэж үзсээр байна. (Хүснэгт 13, 28-аас харна уу)

3) Цагдаагийн байгууллагын алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшилд хамтран ажилладаг бусад байгууллагын зүгээс сэтгэл ханамжийг ерөнхийд нь **(3.43)** буюу сэтгэл ханамж дунд зэрэг гэж үнэлсэн, дунджаас дээгүүр үнэлгээг Төвийн бүс, Улаанбаатар хотод тус тус өгсөн бол, Баруун, Хангайн, Зүүн бүсүүд дунджаас доогуур үнэлгээ өгсөн байна. “Манай орон нутгийн цагдаагийн байгууллагын алба хаагчид харилцааны өндөр соёлтой, стандарт дүрмээ баримтлан ажилладаг” гэсэн асуултад сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ **(3.19)** гарсан нь хамгийн бага үзүүлэлт байсан бол “Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах шаардлагатай үед тэд бэлэн байж, хүлээсэн үүргээ хангалттай биелүүлдэг” гэсэн асуултад хамгийн өндөр үнэлгээ өгчээ **(3.63)**. (Хүснэгт 20)

4) Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь хамтран ажилладаг байгууллагуудын сэтгэл ханамжийн ерөнхий дундаж үнэлгээ (3.74) буюу сэтгэл ханамжтай гэсэн үнэлгээг өгсөн бөгөөд дунджаас дээгүүр үнэлгээг Төвийн бүс болон Улаанбаатар хот өгсөн бол, Баруун, Хангайн, Зүүн бүсүүд дунджаас доогуур үнэлгээ өгсөн байна. “Бид цагдаагийн байгууллагатай хамтран ажилласан тохиолдолд сэтгэл ханамж өндөр байдаг” гэсэн асуултад (3.67), “Манай орон нутгийн аюулгүй байдлыг цагдаагийн байгууллага хангаж чадна гэдэгт бид итгэдэг” гэсэн асуултад (3.82) буюу сэтгэл ханамж сайн гэж үнэлсэн байна. (Хүснэгт 20)

5) Цагдаагийн байгууллагатай хамтран ажилладаг нийт байгууллагаас хамтран ажиллахад хялбар болон хүндрэлтэй байдаг талаар 332 санал ирүүлснээс хамгийн олон давталттай эерэг санал нь цагдаагийн байгууллагатай хамтран ажиллахад шуурхай, итгэлтэй, хариуцлагатай, хялбар байдаг гэж 108 санал буюу 35.6%, хамгийн олон давтагдсан сөрөг саналд ёс зүй, харилцаа хандлага доголдолтой, дээрэнгүй, соёлгүй, албан тушаал ялгаж харьцдаг, асар их чирэгдэл учруулдаг, хүнд сурталтай, хэрэг шийдэхэд удаан, албан бичгийн хариуг хугацаанд нь өгдөггүй, албан хаагчид нь хуулийн мэдлэг дутуу, ур чадвар муу, ажлын ачаалал их, орон тоог нэмэх хэрэгтэй гэсэн асуудал багтсан байна. (63%)

### ЗӨВЛӨМЖ

1. Цагдаагийн байгууллагын хэрэглэгчийн үнэлгээний судалгааны бүрдэл хэсэгт хамтран ажилладаг байгууллагын сэтгэл ханамжийн судалгааг тогтмол оруулах, судалгаанд оролцогчдын тоо, санхүүжилтийг нэмэгдүүлэх, судалгаа явуулах, дүн шинжилгээ хийх аргачлалд шинжлэх ухаанч байдлаар хандаж бодит дүгнэлт гаргахад онцгой анхаарах;
2. Тухайн жилийн үнэлгээг өмнөх жилийн үнэлгээтэй харьцуулах замаар хэрэглэгчийн үнэлгээнд гарч байгаа өөрчлөлтөд дүн шинжилгээ хийж, үр дүнг үндэслэн хариуцлага хүлээлгэх, урамшуулах тогтолцоонд шилжих;
3. Алба хаагчдын харилцааны соёл, ёс зүй төлөвшилт, эрх зүйн мэдлэг, ур чадварыг сайжруулах, байгууллагын дотоод соёлыг төлөвшүүлэх, шинээр цагдаагийн албанд орох алба хаагчдыг сонгон шалгаруулж авахдаа ёс зүй, харилцааны соёлд өндөр

шаардлага тавих, зөрчил дутагдал гаргасан шалтгаан нөхцөлийг бодитойгоор тогтоож холбогдох арга хэмжээг шударгаар авч байх

4. Хуулийн хүрээнд ил болгох боломжтой мэдээллийн талаар оршин сууж буй нутаг дэвсгэрийнхээ иргэдэд мэдээлэл, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулж байх зэрэг болно.



ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ  
ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ-2017

**Гурав. УЛААНБААТАР ХОТЫН ЦАГДААГИЙН  
АЛБА ХААГЧДЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН  
СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

## 1. УДИРТГАЛ

### 1.1 Судалгааны үндэслэл, шаардлага

Монгол Улсын Засгийн Газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын шалгуур үзүүлэлт”, Хууль зүйн сайдын 2014 оны А/01 дүгээр тушаалаар батлагдсан “Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт-шинжилгээ үнэлгээний аргачлал”-ийг үндэслэн Цагдаагийн Ерөнхий Газар хэрэглэгчийн үнэлгээний тайланг жил бүр гаргах үүрэг хүлээсэн. Энэ ажлын хүрээнд 2012-2016 оны хооронд Цагдаагийн Ерөнхий Газрын захиалгаар хөндлөнгийн судалгааны байгууллагууд “Цагдаагийн байгууллагын хэрэглэгчийн үнэлгээний тайлан”-г 5 удаа гаргаж ирсний бүрэлдэхүүн хэсэгт алба хаагчдын сэтгэл ханамжийн судалгаа багтаж иржээ. Судалгааны ерөнхий дүнгээс үзвэл алба хаагчдын албандаа хандах сэтгэл ханамж төдийлөн нэмэгдэхгүй байгаа талаар дурджээ.

### 1.2 Судалгааны ажлын зорилго, зорилт

Цагдаагийн алба хаагчдын албандаа хандах сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлж, цаашид авах арга хэмжээний талаар зөвлөмж боловсруулахад оршино.

### 1.3 Судалгааны ажлын онцлог

Цагдаагийн байгууллагын хэрэглэгчийн үнэлгээг тодорхойлох зорилгоор өмнө нь явуулсан судалгаа нь ихэнх тохиолдолд Улаанбаатар хотын дүүргүүдийн иргэд алба хаагчдын дунд явуулдаг байсан бол энэ удаа нийслэлийн 6 дүүрэг, 21 аймгийн цагдаагийн газар, хэлтсийн алба хаагчдын төлөөллийг оролцуулсан. Судалгааны үр дүнг Улаанбаатар хотын дүүрэг, аймаг тус бүрээр нь гаргаж, дундаж оноогоор нь эрэмбэлэн харуулсан зэрэг онцлогтой.

### 1.4 Судалгааны арга зүй, түүвэрлэлт

Судалгааны ажлын зорилгод нийцүүлэн цагдаагийн алба хаагчдын ажлын байрны сэтгэл ханамжийн үнэлгээг тодорхойлох асуулгыг 8 бүлэг 30 асуулттайгаар боловсруулж, үзүүлэлт бүрийг Ликертийн хэмжүүрээр 5 хүртэл оноогоор үнэлж, алба хаагчийн үнэлгээний түвшинг бүлэг тус бүрээр болон нэгдсэн дүнгээр тодорхойлов.

#### Мэдээлэл цуглуулалт

Судалгааг Нээлтэй Нийгэм Форум хүрээлэнгийн Улаанбаатар хот, орон нутаг дахь судалгааны салбар байгууллагуудаар дамжуулан гүйцэтгэсэн. Судалгаа явуулах судлаачдад судалгаа явуулах арга зүй, аюулгүй байдлаа хангах сургалт, урьдчилсан тестийг 2017 оны 08 дугаар сарын 24-ний өдөр Шүүхийн ерөнхий зөвлөлийн сургалтын төвд явуулж, орон нутаг дахь судалгааг 2017 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 06-ны хооронд, Улаанбаатар хот дахь судалгааг 2017 оны 12 дугаар сарын 03-ний өдрөөс 12 дугаар сарын 20-ны өдрийн хооронд нүүр тулсан ярилцлага хийх замаар мэдээллийг цуглуулсан.

#### Мэдээлэл боловсруулалт

Судалгааны мэдээллийг SPSS.21 програм дээр боловсруулж, тайланг хэрэглэгчдэд ойлгомжтой, хүртээмжтэй болгох үүднээс Монгол Улсын Үндэсний статистикийн хорооноос эрхлэн гаргадаг “Монгол улсын статистикийн эмхтгэл”-ийн аргачлалд тулгуурлан Улаанбаатар хот, 4 бүс гэсэн ангиллаар судалгааны үр дүнг харуулж, харьцуулалт хийв.

Үзүүлэлт бүрийн жигнэсэн дундаж, дээд, доод утга, медиан, стандарт хазайлт зэрэг статистик үзүүлэлтийг тооцохын зэрэгцээ, үзүүлэлтүүд хоорондын хамаарлыг статистик шинжүүрийн тусламжтайгаар тооцон тодорхойлж, зохих сорил шинжүүрээр шалгаж магадлав.

## 1.5 Судалгааны хамрах хүрээ, хязгаарлалт

Цагдаагийн алба хаагчдын ажлын байранд дахь сэтгэл ханамжийг үнэлэх судалгааг 21 аймаг, нийслэлийн 6 дүүргийн хэмжээнд хязгаарыг тогтоож, тухайн ажлын байрандаа 1-ээс дээш жил ажилласан алба хаагчдын хүрээнд судалгааг явуулав.

Улаанбаатар хотын 6 дүүрэгт нийт 14 цагдаагийн хэлтэс үйл ажиллагаа явуулж байгаа ба дүүрэг дэх цагдаагийн хэлтэс бүрээс төлөөлөл ороогүй болно. Тиймээс тайланд дурдагдсан нийслэлийн дүүргүүдийн дүн нь хэлтэс тус бүрээрээ гараагүйг анхаарах нь зүйтэй.

## 2. СТАТИСТИК МЭДЭЭНД ЗОРИУЛСАН ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ

### 2.1. Судалгаанд оролцсон Улаанбаатар хотын цагдаагийн алба хаагчдын шинж байдал

Үзүүлэлт	Шинж байдал	Улаанбаатар хот
Хүйс	Эрэгтэй	71
	Эмэгтэй	17
Нас	20-29	27
	30-39	38
	40-49	21
	50 ба түүнээс дээш	2
Ажилладаг алба	Мөрдөх алба	11
	Эрүүгийн мөрдөх алба	24
	Нийтийн хэв журам хамгаалах алба	33
	Замын цагдаагийн алба	2
	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх алба	4
	Захиргаа, хүний нөөц	8
	Бусад	6
Ажил эрхэлж буй нэгж	Цагдаагийн ерөнхий газар	-
	Нийслэлийн цагдаагийн газар	6
	Аймаг, дүүргийн цагдаагийн газар хэлтэс	81
	Сум, хорооны цагдаагийн нэгж	1
Цагдаагийн цол	Цагдаагийн ахлагч бүрэлдэхүүн	27
	Цагдаагийн дунд офицер	44
	Цагдаагийн ахлах офицер	16
	Цагдаагийн дээд офицер	1
Ажлын чиг үүрэг	Гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэгтэй	75
	Гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэггүй	13
Ажилласан жил	5 хүртэлх	16
	5-10	25
	10-15	20
	15-20	16
	20 ба түүнээс дээш	11

## 3. ЦАГДААГИЙН АЛБАН ХААГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ЕРӨНХИЙ БАЙДАЛ

### 3.5 Улаанбаатар хотын цагдаагийн албан хаагчийн сэтгэл ханамжийн үнэлгээ

Аймаг	Би цагдаагийн алба хаагч гэж өөрөөрөө үргэлж бахархдаг	Миний гэр бүлийн гишүүд намайг цагдаагийн алба хаагч гэдгээр бахархдаг	Би одоогийн ажлын байр, үүрэгт ажилдаа сэтгэл хангалуун байдаг	Дундаж	Стандарт хазайлт
Баянгол	4.47	4.33	3.80	4.20	0.865
Сонгинохайрхан	<b>3.64</b>	<b>3.43</b>	<b>3.14</b>	<b>3.40</b>	0.849

Сүхбаатар	4.57	4.50	4.29	4.45	0.744
Чингэлтэй	4.40	4.13	3.80	4.11	1.022
Баянзүрх	4.20	4.07	3.53	3.93	1.137
Хан-Уул	4.07	3.80	4.00	3.96	0.832
<b>Ерөнхий дундаж</b>	<b>4.23</b>	<b>4.04</b>	<b>3.76</b>	<b>4.01</b>	<b>0.908</b>

Тайлбар:огт санал нийлэхгүй-1, санал нийлэхгүй-2, дунд зэрэг-3, санал нийлнэ-4, бүрэн санал нийлнэ-5


Дээрх хүснэгтээс харахад Улаанбаатар хотын 6 дүүргийн 88 албан хаагч судалгаанд оролцсон бөгөөд цагдаагийн албан хаагчийн сэтгэл ханамжийн ерөнхий үнэлгээ нь **4.01** байгаа нь ажилдаа сэтгэл ханамж өндөр байгааг харуулж байна. Ерөнхий стандарт хазайлт нь **0.908** байгаа нь алдаа бага байгааг харуулж байна.

**“Би цагдаагийн алба хаагч гэж өөрөөрөө үргэлж бахархдаг”** гэдэг асуултанд албан хаагчдын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ **4.23** бөгөөд дунджаас дээгүүр үнэлгээг Баянгол, Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн албан хаагчид өгсөн бөгөөд Баянзүрх, Хан-Уул дүүргийн албан хаагчид дунджаас доогуур үнэлгээ өгсөн байна.

**“Миний гэр бүлийн гишүүд намайг цагдаагийн алба хаагч гэдгээр бахархдаг”** гэдэг асуултанд албан хаагчдын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ **4.04** бөгөөд дунджаас дээгүүр үнэлгээ өгсөн нь дүүргүүд Баянгол, Сүхбаатар, Чингэлтэй, Баянзүрх бөгөөд Сонгинохайрхан, Хан-Уул дүүргүүд дунджаас доогуур үнэлгээ өгсөн байна.

**“Би одоогийн ажлын байр, үүрэгт ажилдаа сэтгэл хангалуун байдаг”** гэдэг асуултанд албан хаагчдын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ **3.76** бөгөөд Баянгол, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул дүүргүүд дунджаас дээгүүр Сонгинохайрхан, Баянзүрх дүүргүүд дунджаас доогуур үнэлгээ өгсөн байна. Үүнийг дараах зургаар илэрхийлье.

Улаанбаатар хотын цагдаагийн албан хаагчийн сэтгэл ханамжийн үнэлгээ /дүүргээр/



#### 4. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН БОДЛОГО, ҮНДСЭН ЧИГ ҮҮРГИЙН ТАЛААР

##### 4.5 Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын бодлого, үндсэн чиг үүрэг

Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын бодлого, үндсэн чиг үүргийн талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ, /дүүргээр/

Аймаг	Цагдаагийн байгууллага жил бүр тодорхой зорилт дэвшүүлж, түүнийг үр дүнтэй биелүүлж ажилладаг	Цагдаагийн байгууллагын орон тоо гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулахад хүрэлцэхүйц тул ажлын ачаалал хэвийн байдаг	Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг мэргэжлийн түвшинд гүйцэтгэж чаддаг	Цагдаагийн байгууллага нь хэв журам сахиулах, нийтийг хамарсан жагсаал цуглааны үед мэргэжлийн түвшинд ажиллаж чаддаг	Дундаж	Стандарт хазайлт
Баянгол	<b>3.93</b>	2.33	<b>4.00</b>	<b>3.87</b>	<b>3.53</b>	0.773
Сонгинохайрхан	<b>2.86</b>	<b>2.07</b>	<b>3.21</b>	3.36	2.88	0.893
Сүхбаатар	3.57	2.21	3.43	3.36	3.14	0.826
Чингэлтэй	3.60	2.27	3.34	3.53	3.18	0.913
Баянзүрх	3.47	2.27	3.33	3.60	<b>3.17</b>	1.012
Хан-Уул	3.60	<b>2.73</b>	3.33	<b>3.33</b>	3.25	0.707
<b>Ерөнхий дундаж</b>	<b>3.51</b>	<b>2.31</b>	<b>3.44</b>	<b>3.51</b>	<b>3.19</b>	<b>0.854</b>

Тайлбар:огт санал нийлэхгүй-1, санал нийлэхгүй-2, дунд зэрэг-3, санал нийлнэ-4, бүрэн санал нийлнэ-5

Дээрх хүснэгтээс харахад Улаанбаатар хотын 6 дүүргийн 88 албан хаагч судалгаанд оролцсон бөгөөд цагдаагийн албан хаагчийн сэтгэл ханамжийн ерөнхий үнэлгээ нь **3.19** байгаа нь ажилдаа сэтгэл ханамж дунд зэрэг, ерөнхий стандарт хазайлт нь **0.854** байгаа нь алдаа бага байгааг харуулж байна.


“Цагдаагийн байгууллага жил бүр тодорхой зорилт дэвшүүлж, түүнийг үр дүнтэй биелүүлж ажилладаг” гэдэг асуултанд албан хаагчдын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ **3.51** бөгөөд дунджаас дээгүүр үнэлгээг Баянгол, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул дүүргийн албан хаагчид өгсөн бөгөөд Сонгинохайрхан, Баянзүрх дүүргийн албан хаагчид дунджаас доогуур үнэлгээ өгсөн байна.

“Цагдаагийн байгууллагын орон тоо гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулахад хүрэлцэхүйц тул ажлын ачаалал хэвийн байдаг” гэдэг асуултанд албан хаагчдын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ **2.31** бөгөөд дунджаас дээгүүр үнэлгээ өгсөн нь Баянгол, Хан-Уул дүүрэг бөгөөд Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй, Баянзүрх дүүргүүд дунджаас доогуур үнэлгээ өгсөн байна.

“Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг мэргэжлийн түвшинд гүйцэтгэж чаддаг” гэдэг асуултанд албан хаагчдын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ **3.44** бөгөөд Баянгол дүүрэг дунджаас дээгүүр Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй, Баянзүрх, Хан-Уул дунджаас доогуур үнэлгээ өгсөн байна.

“Цагдаагийн байгууллага нь хэв журам сахиулах, нийтийг хамарсан жагсаал цуглааны үед мэргэжлийн түвшинд ажиллаж чаддаг” гэдэг асуултанд албан хаагчдын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ **3.51** бөгөөд Баянгол, Чингэлтэй, Баянзүрх дүүргүүд дунджаас дээгүүр Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул дүүргүүд дунджаас доогуур үнэлгээ өгсөн байна. Үүнийг дараах зургаар илэрхийлье.

Улаанбаатар хотын цагдаагийн албан хаагчийн сэтгэл ханамжийн үнэлгээ /дүүргээр/



## 5. ХУУЛЬ ЁСНЫ БАЙДАЛ

### 5.5 Улаанбаатар хотын хууль ёсны байдал

Улаанбаатар хотын цагдаагийн албан хаагчийн хууль ёсны байдлын талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ /дүүргээр/

Аймаг	Цагдаагийн алба хаагчид үйл ажиллагаандаа хуулийг нэг мөр баримтлан ажилладаг	Байгууллагын хэмжээнд алба хаагчтай холбоотой гаргаж байгаа шийдвэр нь Монгол улсын хууль тогтоомжид ихэвчлэн нийцсэн байдаг	Алба хаагчтай холбоотой хууль бус шийдвэр гарсан тохиолдолд түүнийг засах, хөндөгдсөн эрх, ашиг сонирхлыг сэргээн эдлүүлэх талаар бүх арга хэмжээг авдаг	Дундаж	Стандарт хазайлт
Баянгол	4.07	3.53	2.87	3.49	0.648
Сонгинохайрхан	3.50	3.36	2.36	3.07	0.718
Сүхбаатар	3.86	3.50	2.71	3.36	0.670
Чингэлтэй	3.93	3.40	3.07	3.47	0.796
Баянзүрх	3.60	3.40	2.60	3.20	1.075
Хан-Уул	3.67	3.47	2.87	3.34	0.724
<b>Ерөнхий дундаж</b>	<b>3.77</b>	<b>3.44</b>	<b>2.75</b>	<b>3.32</b>	<b>0.772</b>

Тайлбар:огт санал нийлэхгүй-1, санал нийлэхгүй-2, дунд зэрэг-3, санал нийлнэ-4, бүрэн санал нийлнэ-5

Дээрх хүснэгтээс харахад хууль ёсны байдлын талаарх сэтгэл ханамжийг Улаанбаатар хотын хувьд **3.32** гэж үнэлсэн бөгөөд Баянгол, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул дүүрэг дунджаас дээгүүр үнэлгээг Сонгинохайрхан, Баянзүрх дүүргүүд дунджаас доогуур үнэлжээ.


“Цагдаагийн алба хаагчид үйл ажиллагаандаа хуулийг нэг мөр баримтлан ажилладаг” гэдэг асуултанд албан хаагчдын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ **3.77** бөгөөд Баянгол, Сүхбаатар,

Чингэлтэй дүүргийн албан хаагчид дунджаас дээгүүр Сонгинохайрхан, Баянзүрх, Хан-Уул дүүргүүд дунджаас доогуур үнэлжээ.

“Байгууллагын хэмжээнд алба хаагчтай холбоотой гаргаж байгаа шийдвэр нь Монгол улсын хууль тогтоомжид ихэвчлэн нийцсэн байдаг” гэдэг асуултанд албан хаагчдын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ **3.44** бөгөөд Баянгол, Сүхбаатар, Хан-Уул дүүргүүд дунджаас дээгүүр үнэлгээг харин Сонгинохайрхан, Чингэлтэй, Баянзүрх дүүргүүд дунджаас доогуур үнэлжээ.

“Алба хаагчтай холбоотой хууль бус шийдвэр гарсан тохиолдолд түүнийг засах, хөндөгдсөн эрх, ашиг сонирхлыг сэргээн эдлүүлэх талаар бүх арга хэмжээг авдаг” гэдэг асуултанд албан хаагчдын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ **2.75** бөгөөд Баянгол, Чингэлтэй, Хан-Уул дүүргүүд дунджаас дээгүүр харин Сонгинохайрхан, Сүхбаатар, Баянзүрх дүүргүүд дунджаас доогуур үнэлгээ өгсөн байна. Энэ асуултын хувьд Улаанбаатар хотын албан хаагчдын сэтгэл ханамж муу байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл шударга бус ханддаг гэдгийг харуулж байна. Үүнийг дараах зургаар илэрхийлье.

Улаанбаатар хотын цагдаагийн албан хаагчийн хууль ёсны байдлын талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ



## 6.5 БОЛОВСОН ХҮЧНИЙ БОДЛОГО

### 6.5 Улаанбаатар хотын боловсон хүчний бодлого

Дүүрэг	Цагдаагийн байгууллагын өнөөгийн бодлого, түүний хэрэгжилт нь алба хаагч бүрийг албан тушаал дэвших бололцоог жигд хангасан байдаг	Цагдаагийн алба хаагчдыг томилогдсон ажилд нь тогтвор суурьшилтай ажиллуулах бодлоготой	Албан тушаал дэвшүүлэх, цол олгох ажил хууль, журамд заасны дагуу явагддаг
Баянгол	2.73	3.47	3.33
Баянзүрх	2.73	2.93	2.93
Сонгинохайрхан	2.67	2.44	2.89
Сүхбаатар	2.57	3.14	3.29
Хан-Уул	2.80	2.93	3.20
Чингэлтэй	2.33	3.00	2.80
<b>Ерөнхий дундаж</b>	<b>2.64</b>	<b>2.99</b>	<b>3.07</b>

Аймаг	ЦАХ-дын ажил дүгнэх үзүүлэлт нь бодитой, шударга байдаг	Алба хаагчийг шагнах, урамшуулах тогтолцоо оновчтой, шударга байдаг	Алба хаагчид хариуцлага тооцох тогтолцоо оновчтой, шударга байдаг	Алба хаагчдын мэдлэг, боловсролыг дээшлүүлэх талаар хангалттай дэмжлэг үзүүлдэг	Дундаж	Стандарт хазайлт
Баянгол	2.87	2.67	3.40	3.00	<b>3.07</b>	0.937
Баянзүрх	2.93	2.93	2.93	2.47	2.84	1.197
Сонгино хайрхан	<b>2.67</b>	<b>2.44</b>	3.22	3.00	2.76	0.764
Сүхбаатар	<b>3.14</b>	<b>3.00</b>	3.07	2.71	2.99	0.650
Хан-Уул	2.80	2.87	3.13	3.20	2.99	0.763
Чингэлтэй	2.80	2.67	2.67	2.40	<b>2.67</b>	1.075
<b>Ерөнхий дундаж</b>	<b>2.87</b>	<b>2.76</b>	<b>3.07</b>	<b>2.80</b>	<b>2.89</b>	<b>0.898</b>

Тайлбар:огт санал нийлэхгүй-1, санал нийлэхгүй-2, дунд зэрэг-3, санал нийлнэ-4, бүрэн санал нийлнэ-5

Дээрх хүснэгтээс харахад боловсон хүчний бодлогын талаарх сэтгэл ханамжийг Улаанбаатар хотын хувьд **2.89** гэж үнэлсэн бөгөөд дунджаас дээгүүр үнэлгээг Баянгол, Чингэлтэй дүүргүүд харин Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул зэрэг дүүргүүд дунджаас доогуур үнэлжээ.

“Цагдаагийн байгууллагын өнөөгийн бодлого, түүний хэрэгжилт нь алба хаагч бүрийг албан тушаал дэвших бололцоог жигд хангасан байдаг” гэдэг асуултанд албан хаагчдын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ **2.64** бөгөөд Баянгол, Хан-Уул, Чингэлтэй зэрэг дүүргийн албан хаагчид дунджаас дээгүүр Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргүүд дунджаас доогуур үнэлжээ.

“Цагдаагийн алба хаагчдыг томилогдсон ажилд нь тогтвор суурьшилтай ажиллуулах бодлоготой” гэдэг асуултанд албан хаагчдын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ **2.99** бөгөөд Баянгол, Сүхбаатар, Чингэлтэй зэрэг дүүргийн албан хаагчид дунджаас дээгүүр Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргүүд дунджаас доогуур үнэлжээ.

“Албан тушаал дэвшүүлэх, цол олгох ажил хууль, журамд заасны дагуу явагддаг” гэдэг асуултанд албан хаагчдын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ **3.07** бөгөөд Баянгол, Сүхбаатар, Хан-Уул зэрэг дүүргийн албан хаагчид дунджаас дээгүүр Баянзүрх, Сонгинохайрхан, Чингэлтэй зэрэг дүүргүүд дунджаас доогуур үнэлжээ.

“Цагдаагийн алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлт нь бодитой бөгөөд шударга байдаг” гэдэг асуултанд албан хаагчдын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ **2.87** бөгөөд Баянгол, Сүхбаатар, Баянзүрх зэрэг дүүргийн албан хаагчид дунджаас дээгүүр, Чингэлтэй, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргүүд дунджаас доогуур үнэлжээ.


“Алба хаагчийг шагнах, урамшуулах тогтолцоо оновчтой, шударга байдаг” гэдэг асуултанд албан хаагчдын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ **3.76** бөгөөд Сүхбаатар, Баянзүрх, Хан-Уул зэрэг дүүргийн албан хаагчид дунджаас дээгүүр, Баянгол, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргүүд дунджаас доогуур үнэлжээ.

“Алба хаагчид хариуцлага тооцох тогтолцоо оновчтой, шударга байдаг” гэдэг асуултанд албан хаагчдын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ **3.07** бөгөөд Баянгол, Сүхбаатар, Сонгинохайрхан, Хан-Уул зэрэг дүүргийн албан хаагчид дунджаас дээгүүр, Баянзүрх, Чингэлтэй дүүргүүд дунджаас доогуур үнэлжээ.



“Алба хаагчдын мэдлэг, боловсролыг дээшлүүлэх талаар хангалттай дэмжлэг үзүүлдэг” гэдэг асуултанд албан хаагчдын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 2.8 бөгөөд Баянгол, Сонгинохайрхан, Хан-Уул зэрэг дүүргийн албан хаагчид дунджаас дээгүүр, Сүхбаатар, Баянзүрх, Чингэлтэй дүүргүүд дунджаас доогуур үнэлжээ. Хэдийгээр дундажтай харьцуулахад доогуур боловч энэ нь сэтгэл ханамж муу байна гэсэн үг биш юм.

**Улаанбаатар хотын боловсон хүчний бодлогын талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ**



**7. БАЙГУУЛЛАГЫН СОЁЛ, АЛБА ХААГЧИЙН ЁС ЗҮЙ**

**7.5 Улаанбаатар хотын байгууллагын соёл, алба хаагчийн ёс зүй**

Улаанбаатар хотын байгууллагын соёл, алба хаагчийн ёс зүйн талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ

Дүүрэг	Цагдаагийн байгууллагын орчинд авилга, хүнд суртлын асуудал байдаггүй	Алба хаагч бүр цагдаагийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээг удирдлага болгон бие биедээ хүндэтгэлтэй хандаж ажилладаг	Цагдаагийн байгууллагын төвлөрсөн нэгдмэл тогтолцоо, хагас цэргийн зохион байгуулалт нь ажлын байрны тодорхойлолтод заасан үүргээ гүйцэтгэхэд хүндрэл учруулдаггүй	Дундаж	Стандарт хазайлт
Баянгол	3.47	<b>3.93</b>	3.53	3.64	0.872
Баянзүрх	<b>2.87</b>	<b>3.2</b>	<b>3.6</b>	3.22	1.145
Сонгинохайрхан	<b>3.14</b>	3.14	3.36	<b>3.21</b>	0.874
Сүхбаатар	3.43	3.14	3.29	3.29	0.709
Хан-Уул	3.2	<b>3.2</b>	<b>3.27</b>	3.22	0.774
Чингэлтэй	3.8	3.8	3.4	<b>3.67</b>	0.953
<b>Ерөнхий дундаж</b>	<b>3.32</b>	<b>3.4</b>	<b>3.41</b>	<b>3.38</b>	<b>0.888</b>

Тайлбар:огт санал нийлэхгүй-1, санал нийлэхгүй-2, дунд зэрэг-3, санал нийлнэ-4, бүрэн санал нийлнэ-5


Дээрх хүснэгтээс харахад байгууллагын соёл, алба хаагчийн ёс зүй талаарх сэтгэл ханамжийг Улаанбаатар хотын 6 дүүргийн хувьд **3.38** гэж үнэлсэн бөгөөд дунджаас дээгүүр үнэлгээг Баянгол, Чингэлтэй дүүргүүд харин Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул дунджаас доогуур үнэлжээ.

“Цагдаагийн байгууллагын орчинд авилга, хүнд суртлын асуудал байдаггүй” гэдэг асуултанд албан хаагчдын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ **3.32** бөгөөд дунджаас дээгүүр үнэлгээг Баянгол, Чингэлтэй, Сүхбаатар дүүргүүд харин Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул дунджаас доогуур үнэлжээ.

“Алба хаагч бүр цагдаагийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээг удирдлага болгон бие биедээ хүндэтгэлтэй хандаж ажилладаг” гэдэг асуултанд албан хаагчдын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ **3.40** бөгөөд дунджаас дээгүүр үнэлгээг Баянгол, Чингэлтэй дүүргүүд харин Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул дунджаас доогуур үнэлжээ.

“Цагдаагийн байгууллагын төвлөрсөн нэгдмэл тогтолцоо, хагас цэргийн зохион байгуулалт нь ажлын байрны тодорхойлолтод заасан үүргээ гүйцэтгэхэд хүндрэл учруулдаггүй” гэдэг асуултанд албан хаагчдын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ **3.41** бөгөөд дунджаас дээгүүр үнэлгээг Баянгол, Баянзүрх дүүргүүд харин Чингэлтэй, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул дунджаас доогуур үнэлжээ. Хэдийгээр дундажтай харьцуулахад доогуур боловч энэ нь сэтгэл ханамж муу байна гэсэн үг биш юм. Үүнийг дараах зургаар илэрхийлье.

Улаанбаатар хотын байгууллагын соёл, алба хаагчийн ёс зүйн талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ



8. УДИРДЛАГЫН МАНЛАЙЛАЛ

8.5 Улаанбаатар хотын цагдаагийн албан хаагчийн удирдлагын манлайлал

Улаанбаатар хотын цагдаагийн албан хаагчийн удирдлагын манлайллын талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ /дүүргээр/

Аймаг	Манай дээд шатны дарга нар мэргэжлийн ур чадвар, ажлын туршлага, ёс зүйн төлөвшлийн хувьд алба хаагчиддаа хүлээн зөвшөөрөгдөж чадсан	Цагдаагийн удирдах ажилтны шийдвэр нь алба хаагчдын эрх, хууль ёсны ашиг сонирхолд нийцдэг	Манай удирдах албан тушаалтан бидний санал хүсэлтийг сонсож, асуудлыг хамтран шийддэг	Зөрчил дутагдал гаргасан алба хаагчдын шалтгаан нөхцөлийг зөв тогтоож, шийдвэр гаргадаг	Дундаж	Стандарт хазайлт
Баянгол	3.27	3.27	3.40	3.33	3.32	1.02
Сонгинохайрхан	2.86	3.07	3.00	3.07	3.00	0.85
Сүхбаатар	3.29	3.21	3.14	3.07	3.18	0.65
Чингэлтэй	3.07	3.20	3.20	3.20	3.17	1.14
Баянзүрх	3.13	2.87	3.07	2.93	3.00	1.16
Хан-Уул	3.60	3.27	3.40	3.20	3.37	0.71
<b>Ерөнхий дундаж</b>	<b>3.20</b>	<b>3.15</b>	<b>3.20</b>	<b>3.13</b>	<b>3.17</b>	<b>0.92</b>

Тайлбар:огт санал нийлэхгүй-1, санал нийлэхгүй-2, дунд зэрэг-3, санал нийлнэ-4, бүрэн санал нийлнэ-5

Дээрх хүснэгтээс харахад удирдлагын манлайллын талаарх сэтгэл ханамжийг Улаанбаатар хотын хувьд **3.17** гэж үнэлсэн бөгөөд Баянгол, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул дүүргүүд дунджаас дээгүүр үнэлгээг харин Сонгинохайрхан, Баянзүрх дүүргүүд дунджаас доогуур үнэлжээ.


“Манай дээд шатны дарга нар мэргэжлийн ур чадвар, ажлын туршлага, ёс зүйн төлөвшлийн хувьд алба хаагчиддаа хүлээн зөвшөөрөгдөж чадсан” гэдэг асуултанд албан хаагчдын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ **3.20** бөгөөд Баянгол, Сүхбаатар, Хан-Уул дүүргүүдийн албан хаагчид дунджаас дээгүүр харин Чингэлтэй, Сонгинохайрхан, Баянзүрх дүүргүүд дунджаас доогуур үнэлжээ.

“Цагдаагийн удирдах ажилтны шийдвэр нь алба хаагчдын эрх, хууль ёсны ашиг сонирхолд нийцдэг” гэдэг асуултанд албан хаагчдын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 3.15 бөгөөд Баянгол, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул дүүргүүд дунджаас дээгүүр үнэлгээг өгсөн бол Сонгинохайрхан, Баянзүрх дүүргүүд дунджаас доогуур үнэлжээ.

“Манай удирдах албан тушаалтан бидний санал хүсэлтийг сонсож, асуудлыг хамтран шийддэг” гэдэг асуултанд албан хаагчдын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 3.20 бөгөөд Баянгол, Чингэлтэй, Хан-Уул дүүргүүд албан хаагчид дунджаас дээгүүр харин Сонгинохайрхан, Сүхбаатар, Баянзүрх дүүргүүд дунджаас доогуур үнэлжээ.

“Зөрчил дутагдал гаргасан алба хаагчдын шалтгаан нөхцөлийг зөв тогтоож, шийдвэр гаргадаг” гэдэг асуултанд албан хаагчдын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 3.13 бөгөөд Баянгол, Чингэлтэй, Хан-Уул дүүргүүд албан хаагчид дунджаас дээгүүр харин Сонгинохайрхан, Сүхбаатар, Баянзүрх дунджаас доогуур үнэлжээ. Хэдийгээр дундажтай харьцуулахад доогуур боловч энэ нь сэтгэл ханамж муу байна гэсэн үг биш юм. Үүнийг дараах зургаар илэрхийлье.

Удирдлагын манлайллын талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ



## 9. АЛБА ХААГЧИЙН БАТАЛГАА

### 9.5 Улаанбаатар хотын алба хаагчийн баталгаа

Улаанбаатар хотын алба хаагчийн баталгааны талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ /дүүргээр/

Дүүрэг	Цагдаагийн алба хаагчийн цалин, төрөөс үзүүлж буй дэмжлэг нь ахуй амьдралд хүрэлцэхүйц байдаг	Шинээр батлагдсан Цагдаагийн албаны тухай хууль биднийг ажил үүргээ гүйцэтгэх нийгэм, улс төр, эрх зүйн баталгааг бүрэн хангаж өгсөн	Цагдаагийн алба хаагч бүр хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд бие даан шийдвэр гаргаж, хараат бусаар ажиллаж чаддаг	Цагдаагийн алба хаагч үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай эдийн засгийн болон техник хэрэгслийн хангалт хэвийн байдаг	Дундаж	Стандарт хазайлт
Баянгол	2.33	<b>3.33</b>	<b>3.20</b>	<b>2.87</b>	2.93	0.994
Баянзүрх	<b>2.87</b>	2.87	3.13	<b>2.87</b>	<b>2.94</b>	1.186
Сонгинохайрхан	2.43	2.93	<b>2.50</b>	2.43	2.57	0.966
Сүхбаатар	2.64	3.00	2.86	2.79	2.82	0.971
Хан-Уул	<b>1.73</b>	<b>2.67</b>	2.87	2.40	<b>2.42</b>	0.958
Чингэлтэй	2.00	2.80	2.73	<b>2.00</b>	<b>2.38</b>	1.004
<b>Ерөнхий дундаж</b>	<b>2.33</b>	<b>2.93</b>	<b>2.88</b>	<b>2.56</b>	<b>2.68</b>	<b>1.013</b>

Тайлбар:огт санал нийлэхгүй-1, санал нийлэхгүй-2, дунд зэрэг-3, санал нийлнэ-4, бүрэн санал нийлнэ-5

Дээрх хүснэгтээс харахад алба хаагчийн баталгааны талаарх сэтгэл ханамжийг Улаанбаатар хотын хувьд **2.68** гэж үнэлсэн бөгөөд дунджаас дээгүүр үнэлгээг Баянгол, Баянзүрх, Сүхбаатар дүүргүүд харин Сонгинохайрхан, Чингэлтэй, Хан-Уул дүүргүүд дунджаас доогуур үнэлжээ.


“Цагдаагийн алба хаагчийн цалин, төрөөс үзүүлж буй дэмжлэг нь ахуй амьдралд хүрэлцэхүйц байдаг” гэдэг асуултанд албан хаагчдын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ **2.33** бөгөөд Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргийн албан хаагчид дунджаас дээгүүр харин Чингэлтэй, Хан-Уул дүүргүүд дунджаас доогуур үнэлжээ.

“Шинээр батлагдсан Цагдаагийн албаны тухай хууль биднийг ажил үүргээ гүйцэтгэх нийгэм, улс төр, эрх зүйн баталгааг бүрэн хангаж өгсөн” гэдэг асуултанд албан хаагчдын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ **2.93** бөгөөд дунджаас дээгүүр үнэлгээг Баянгол, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргүүд өгсөн бол Баянзүрх, Чингэлтэй, Хан-Уул дүүргүүд дунджаас доогуур үнэлжээ.


“Цагдаагийн алба хаагч бүр хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд бие даан шийдвэр гаргаж, хараат бусаар ажиллаж чаддаг” гэдэг асуултанд албан хаагчдын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ **2.88** бөгөөд Баянгол, Баянзүрх албан хаагчид дунджаас дээгүүр харин Сүхбаатар, Сонгинохайрхан, Чингэлтэй, Хан-Уул дүүргүүд дунджаас доогуур үнэлжээ.

“Цагдаагийн алба хаагч үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай эдийн засгийн болон техник хэрэгслийн хангалт хэвийн байдаг” гэдэг асуултанд албан хаагчдын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ **2.56** бөгөөд Баянгол, Баянзүрх, Сүхбаатар дүүргийн албан хаагчид дунджаас дээгүүр харин Сонгинохайрхан, Чингэлтэй, Хан-Уул дүүргүүд дунджаас доогуур үнэлжээ.

Улаанбаатар хотын алба хаагчийн баталгааны талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ




Цагдаагийн байгууллагын өнөөгийн бүтэц, тогтолцоо, хуулиар хүлээсэн үүргээ гүйцэтгэж буй байдалд өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээ



Цагдаагийн байгууллагын өнөөгийн бүтэц, тогтолцоо, хуулиар хүлээсэн үүргээ гүйцэтгэж буй байдалд хэр зэрэг сэтгэл ханамжтай байдаг вэ? гэсэн асуултанд судалгаанд оролцсон цагдаагийн алба хаагчдын 74 буюу 18.4 хувь нь сэтгэл ханамжгүй, 230 буюу 57.2 хувь нь сэтгэл ханамж дунд зэрэг, 98 буюу 24.4 хувь нь сэтгэл ханамжтай гэж хариулжээ.

## 9. ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧДЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА

Зураг 2. Цагдаагийн алба хаагчдын ажлын байран дахь сэтгэл ханамжийн ерөнхий үнэлгээ



### 11.1 Цагдаагийн алба хаагчийн албандаа сэтгэл хангалуун байхад нөлөөлөх хүчин зүйлс

Цагдаагийн алба хаагч нараас санал, хүсэлт авах зорилгоор нээлттэй асуултыг сэтгэл хангалуун болон хангалуун бус хүчин зүйлсийг тоочин бичүүлж авсан бөгөөд дараах сэтгэл хангалуун хүчин зүйлс гэдэгт 139 төрлийн нийт 224 хүчин зүйлсийг нэгтгэсэн. Дэлгэрэнгүй саналыг аймаг, бүсээр Хавсралт.1 –ээс харна уу. Эдгээр саналаас хамгийн олон давтагдаж байгаа 6 бүлэг хүчин зүйлсийг сонгов.

Цагдаагийн алба хаагчийн албандаа сэтгэл хангалуун байхад нөлөөлөх хүчин зүйлс /давталтаар/

№	Сэтгэл хангалуун хүчин зүйлс	Давталт	Эзлэх хувь
1	Иргэддээ нэр хүндтэй, албаараа бахархдаг	75	47.2
2	Ард иргэдийг амгалан тайван байлгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хамгаалах,	30	18.9
3	Гэмт хэрэг зөрчлийг илрүүлэх, үүргээ биелүүлэх үед төрийн албаараа бахархдаг	25	15.7
5	Баталгаатай тохилог ажлын байр	12	7.5

4	Хувцас хэрэгсэл хангамж	9	5.7
6	Хамт олны уур амсгал, хамт олноороо бахархдаг	8	5.0
<b>Дүн</b>		<b>159</b>	<b>100</b>

Дээрх хүснэгтээс харахад цагдаагийн алба хаагч ажилдаа сэтгэл хангалуун байх 224 хүчин зүйлс ирүүлсэн бөгөөд тэдгээрийн 159 буюу нийт саналын 71% эзэлж хамгийн олон давтагдсан 6 бүлэг хүчин зүйлд багцалж байна. Энд хамгийн олон давталттай нь иргэддээ нэр хүндтэй, албаараа бахархдаг гэсэн агуулгатай 75 хүчин зүйл буюу 47.2%, ард иргэдийг амгалан тайван байлгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хамгаалах гэсэн агуулгатай 30 зүйл буюу 18.9%, гэмт хэрэг зөрчлийг илрүүлэх, үүргээ биелүүлэх үед төрийн албаараа бахархдаг 25 буюу 15.7%, баталгаатай тохилог ажлын байр гэсэн агуулгатай 12 буюу 7.5%, хувцас хэрэгсэл хангамж 9 буюу 5.7%, Хамт олны уур амсгал, хамт олноороо бахархдаг 8 буюу 5.0% -ийг тус тус эзэлж байна.

### 11.2 Цагдаагийн алба хаагчийн албандаа сэтгэл хангалуун бус байхад нөлөөлөх хүчин зүйлс

Цагдаагийн алба хаагч нараас албандаа сэтгэл хангалуун бус байх хүчин зүйлсийг тодорхойлох зорилгоор нээлттэй асуулт өгсөн бөгөөд сэтгэл хангалуун бус байхад нөлөөлөх 289 төрлийн 688 хүчин зүйлсийг нэрлэсэн байна. /Дэлгэрэнгүй хүчин зүйлсийг аймаг, бүсээр Хавсралт.2 –ээс харна уу/. Эдгээр саналаас хамгийн олон давтагдаж байгаа 6 бүлэг хүчин зүйлийг сонгов.

#### Цагдаагийн алба хаагчийн албандаа сэтгэл хангалуун бус байхад нөлөөлөх хүчин зүйлс /давталтаар/

№	Сэтгэл хангалуун бус хүчин зүйлс	Хүчин зүйлийн тоо	Эзлэх хувь
1	Цалин хөлс бага, нийгмийн баталгаа хангалтгүй	151	28.9
2	Ажлын ачаалал, стресс ихтэй, орон тоо хүрэлцээгүй	116	22.2
3	Илүү цагаар, цалин хөлсгүй их ажилладаг, ар гэртээ цаг зарцуулах боломж бага	99	19.0
4	Машин техник хэрэгсэл дутагдалтай, чанаргүй хувцастай, хангамж муу	79	15.1
5	Улс төрийн нөлөө их, хууль бус шийдвэр гаргуулах тохиолдол байдаг, хуулийн дагуу ажиллах боломжгүй байдаг	46	8.8
6	Торгуулийн хуудсаар шахах, удирдлагын зарим үүрэг тодорхойгүй, шаардлагагүй бичиг цаасны ажил их	31	5.9
<b>Дүн</b>		<b>522</b>	<b>100</b>

Дээрх хүснэгтээс харахад нийт 688 хүчин зүйлийн 522 буюу 75.9% нь хамгийн олон давтагдсан дээрх 6 бүлэг зүйлд хамаарч байна. Энд хамгийн их хувийг эзэлж байгаа нь Цалин хөлс бага, нийгмийн баталгаа хангалтгүй гэсэн агуулгатай 151 буюу багцалсан хүчин зүйлсийн 28.9%, ажлын ачаалал, стресс ихтэй, орон тоо хүрэлцээгүй гэсэн агуулгатай 116 зүйл буюу 22.2%, илүү цагаар, цалин хөлсгүй их ажилладаг, ар гэртээ цаг зарцуулах боломжгүй гэсэн агуулгатай 99 зүйл буюу 19.0%, машин, техник, хэрэгсэл дутагдалтай, чанаргүй хувцас, хэрэгсэлтэй, хангамж муу гэсэн агуулгатай 79 буюу 15.1%, улс төрийн нөлөө их, хууль бус шийдвэр гаргуулах тохиолдол байдаг, чиг үүргийн дагуу ажиллуулахгүй байх гэсэн агуулгатай 46 буюу 8.8%, торгуулийн хуудсаар шахах, удирдлагын зарим үүрэг тодорхойгүй, шаардлагагүй бичиг цаасны ажил их гэсэн агуулгатай 31 зүйл буюу 5.9% -ийг тус тус эзэлж байна.



## ЗӨВЛӨМЖ

1. Цагдаагийн байгууллагын алба хаагчдын ажлын байран дахь сэтгэл ханамжийн дунджаас доогуур үнэлгээ авсан бүс, аймаг, дүүрэг тус бүр дээр ямар үзүүлэлт дээр анхаарч ажиллах талаар зөвлөмж боловсруулж үнэлгээг нэмэгдүүлэх, дунджаас дээгүүр үнэлгээ авсан бүс, аймаг тус бүр үйл ажиллагаагаа улам сайжруулах шаардлагатай. Судалгааны тайланд дурдагдсан үзүүлэлтүүдээс тус бүр дээр дүн шинжилгээ хийж улсын хэмжээнд дундаж үзүүлэлтийг (4.0) ба түүнээс түвшинд гаргах чиглэлээр ажиллах;
2. Цагдаагийн алба хаагчийн ажлын ачааллыг оновчтой тодорхойлох, гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлыг харгалзан цагдаагийн орон тоо, техник хэрэгслийг нэмэгдүүлэх, шинэчлэн тогтоох, алба хаагчдын цалин хөлс, нийгмийн баталгааг сайжруулах;
3. Алба хаагчдын стресс, түүнийг тайлах арга хэмжээ, албаараа бахархах сэтгэгдэл төрүүлэх соёл олон нийтийн арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх;
4. Цагдаагийн алба хаагчдын ажлын байран дахь сэтгэл ханамжийн судалгааг жил бүр тогтмол явуулж, судалгаанаас гарсан үр дүнг бодлого боловсруулагчид болон удирдлагад ашигладаг байх нөхцөлийг бүрдүүлэх;
5. Судалгааны асуулгыг боловсронгуй болгож олон улсын жишигт нийцүүлэх, судалгаа явуулах хугацааг тогтмолжуулж түүврийн хэмжээг нэмэгдүүлэх зэрэг болно.

----- оОо -----

## Цагдаагийн алба хаагчийн албандаа сэтгэл хангалуун байхад нөлөөлөх хүчин зүйлс

Улаанбаатар хот		
Баянгол дүүрэг	Бусдын төлөө ажиллаж байдаг	1
	Шударга байх	1
	Дэмжиж урам хайрладаг	1
Сонгинохайрхан дүүрэг	Удам залган ажиллаж байгаадаа баяртай байдаг	3
	Гаргасан алдаа дутагдлын шалтгаан нөхцөлийг бүрэн гүйцэт судласан байх	1
	Гаргасан зөрчилд нийцсэн байх	1
	Орон байр	1
	Техник хангамж	1
	Албаны дүрэмт хувцас	1
	Ажил мэргэжил	1
	Төрийн өмнөөс ажил үүрэг гүйцэтгэдэг	1
Сүхбаатар дүүрэг	Нэр хүнд	3
	Хийсэн ажлаа үнэн зөвөөр үнэлүүлэх	3
	Тогтолцоо	1
	Эрх зүйн орчин	1
Чингэлтэй дүүрэг	Цагдаагийн албанд орж ажилсандаа сэтгэл хангалуун	3
	Тус албанд ажиллаж, ГХТ, НХЖХ ажилд өөрийн хувь нэмэрээ оруулж байгаа тул сэтгэл ханамжтай	1
	Амар тайван амьдралын төлөө ажилладаг	1
	ЦБ-д ажиллаж байгаадаа тэр тусмаа МБА-д ажиллаж байгаа нь албандаа дур сонирхолтой учраас сэтгэл хангалуун байдаг	1
	Шударга байх	1
	Төрийн алба хаагч гэдгээрээ бахархадаг	1
	Өөрийн шийдвэр хүсэл зорилгоор орсон тул албандаа сэтгэл хангалуун ажилладаг	1
Баянзүрх дүүрэг	Сэтгэл хангалуун байх хүчин зүйлс	1
	Нийгмийн баталгаатай	1
	Ажиллах орчин, техник тоног төхөөрөмж, хангамж сайтай	1
	Хамт олонтой мөр зэрэгцэн ажиллах	1
	Цагдаагийн алба хаагч, байгууллагын нэр хүндийг хуваалцаж яваа байдал	1
	Алба хаагч бүр ажилдаа дур сонирхолтой байх	1
Хан-Уул дүүрэг	Одоо эрхэлж буй ажил мэргэжлийн бөгөөд сонирхолтой байдаг.	1

Цагдаагийн алба хаагчийн албандаа сэтгэл хангалуун бус байхад нөлөөлөх хүчин зүйлс

Улаанбаатар хот

Баянгол дүүрэг	Ажлын ачаалал тэнцвэржүүлэхгүй байна	1
	Хүний нөөцийн асуудал хангалтгүй ахлагч бүрэлдэхүүн офицер болгох асуудал байнга учир дутагдалтай байдаг	1
	Алба хаагч нарын гэр орон, амьдрал ахуйтай танилцаагүй	1
	Шинээр батлагдсан хууль журамаар ахлагч бүрэлдэхүүнд сургалт зохион байгуулдаггүй. Дан ганц офицер бүрэлдэхүүнд заадаг.	1
	Цалин хөлс маш бага	1
	Ард иргэдэд нэр хүнд унасан	1
	Шударга бус ялгавартай харилцаа	1
	Дарга үнэлэхгүй байх	1
Сонгинохайрхан дүүрэг	Цалин бага	5
	Ажлын ачаалал их	5
	Иргэдийн дунд албаны нэр хүнд муу	3
	Хангалт муу	1
	Гарагасан алдаа зөрчлийн шалтгаан нөхцөлийг бүрэн тогтоодоггүй, шалгагч өөрийн үзэмжээр шийдвэр гаргадаг.	1
	Шагнал урамшил төрийн одон медаль шударга бус олгодог	1
	Дарамттай	1
	Иргэдээс үзүүлж буй сөрөг харилцаа	1
	Цагдаагийн албаны бүтэц тодорхой бус, эрүүгийн мөрдөгч нарын дарамт өндөр	1
	Дарга нар авилгалд автагдаж ажилтнуудад хууль бус шаардлага тавих	1
	Улс төрийн нөлөө дэндүү их	1
Сүхбаатар дүүрэг	Цалин нэмэгдүүлэх	6
	Удирдлагын шийдвэр, ур чадвар муу	3
	Ажлын ачаалал	2
	Иргэдийн таагүй харилцаа, сөрөг хандлага	2
	Шударга бус байдал	2
	Хуучин арга барилтай байгаа нь албан хаагчаа гэсэн сэтгэл байхгүй	1
	Нийгмийн буруутай үзэгдлийн буруутай байдлыг алба хаагч арилгах ёстой мэт бодож байгаа.....	1
	Боловсрол	1
	Үнэлэмж	1
	Нийгмийн баталгааг сайжруулах	1
	Авилагаагүй болж шударгаар хэргийг үнэн зөв шийдэх	1
	Дарга нарын зүгээс алба хаагч нарын хамгаалдаггүй, гомдол гаргасан хүн ирэх юм бол алба хаагч зөв ч бай буруутгадаг	1
	Ажил хаяж явдаг цалин муугаас болж	1
	Ажиллах нөхцөл байдал тогтворгүй	1
	Хуульд заасны дагуу ахиж дэвших асуудал нээлттэй байдаггүй	1
	Нэр хүндгүй, хийсэн ажил дүгнэгдэхгүй үр дүнгүй байх	1
	Хангамж муу	1
	Ажлын үр дүнгийн үнэлэмж тэгш бус	1
	Хүйсийн ялгаа гаргадаг	1
Ажлын байрны стресс	1	
Цаг зав ар гэртээ бага зарцуулдаг	1	
Чингэлтэй дүүрэг	Цагдаагийн алба хаагчдын торгуулийн хуудсаар шахах нь иргэдээс ЦБ-н үнэлэх үнэлэмж, хандлагыг бууруулах хандлагатай байдаг. Ихэвчлэн замын цагдаа жолооч нарын хооронд ийм асуудал гардаг.	10
	Ажлын ачаалал ихтэй байна	4
	Чанаргүй хувцас, хэрэгслэл болсон боловч үзэмж харагдах байдал	3
	Цалин бага	1
	Амралт чөлөөт цаг бага	1
	Зөв зохион байгуулах бичиг хэрэг компьютер бусад техник хэрэгсэл дутмаг	1